



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТЕГ-ЫН ХАРЬЯА НЭГЖИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



info@mta.gov.mn

+976-75751288

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, С.Данзангийн гудамж 4-А

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг бэлтгэсэн:
ТЕГ-ын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний
газрын дарга

Д.Сайханчулуун

ТЕГ-ДАХШҮГ-ын Татварын улсын ахлах байцаагч

О.Давааням

Татварын улсын байцаагч

А.Ариунгэрэл

Б.Базаррагчаа

Л.Даваасүрэн

Б.Мөнхнасан

Т.Тунгалаг

Г.Энх-Амгалан

Улаанбаатар хот 2023 он

Агуулга

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН	5
ХОЁР. ТАТВАР ТӨЛӨГЧДӨД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН .6	
2.1 ААНБ, Хувь хүнийг татвар төлөгчийн бүртгэлд хамруулсан байдал	7
2.2 Татварын төлөгчийн цахимаар ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэсэн байдал.....	7
2.3 Татварын тайлан хүлээн авалтын байдал	8
2.4 Татварын тайлан боловсруулалт, зөрчилтэй тайлан засварлуулсан байдал	12
ГУРАВ. ТАТВАРЫН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, ХУРААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН	13
3.1 Тайлант онд татвар төлөгчдийг татварт хамруулсан байдал	14
3.2 Татварын өр, ногдлын барагдуулалтын түвшин	17
3.3 Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт	21
ДӨРӨВ. ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН	22
4. 1. Татварын хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт	23
4. 2 Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны байдал:	23
ТАВ. ХӨНДЛӨНГИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, БҮРТГЭЛ БА АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН	24
ЗУРГАА. ТӨРИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХЗҮЙ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН	25
6.1 Захиргаа, хүний нөөц, албан хаагчдын сургалттай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн түвшин:	26
6.2 Санхүү болон үр ашигт ажиллагааны түвшин	27
6.3 Хууль, эрх зүйн үйл ажиллагааны түвшин.....	29
ДОЛОО. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТҮВШИН	32
НАЙМ. ЭРДЭС БАЯЛАГ, ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН .34	
ЕС. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТҮВШИН	35
9.1 Мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт хүрсэн түвшин	35
9.2 Дуудлагын төвийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт хүрсэн түвшин.....	35
АРАВ. ЗӨВЛӨМЖ	36
Татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны түвшин	36
Татварын тайлан хүлээн авалтын байдал:.....	37
Татварын орлогын гүйцэтгэл, хураалтын үйл ажиллагааны түвшин	37
Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны түвшин	37
Төрийн захиргаа, хууль эрхзүй, санхүүгийн үйл ажиллагааны түвшин	38
Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийн түвшин.....	38
Мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт хүрсэн түвшин.....	38
Эрдэс баялаг, татварын хэлтсийн үйл ажиллагааны түвшин	39

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ТАТВАРЫН НЭГЖ, ХАРЬЯА НЭГЖИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ӨГСӨН ТАЙЛАН

Татварын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, ТЕГ-ын харьяа татварын нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн зөвлөмж өгөх, удирдлагыг шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд ТЕГ-ын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас харьяа татварын нэгжийн 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг нэгтгэн гаргалаа.

Хяналт, шинжилгээ, үнэлгээний зорилго:

Татварын албаны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг сайжруулж, хариуцлагын тогтолцоог бэхжүүлснээр иргэдийн татварын албанд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, Татварын албаны удирдлагын төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахад оршино.

Хяналт, шинжилгээ, үнэлгээний зорилт:

Татварын албаны үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилт, холбогдох эрх зүйн актад татварын талаар туссан арга хэмжээ, стратеги зорилтын хүрээнд төлөвлөсөн ажлуудын хэрэгжилт, үр дүнг нягтлан тогтоож, татварын албаны үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн менежментийг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмжөөр хангахад чиглэгдэнэ.

Хамарсан хүрээ:

2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, хүрсэн үр дүнг тодорхойлсон мэдээ, тайлан, судалгаа, баримт материал, ТБМНС-д бүртгэсэн тоо, мэдээ, хавсаргасан нотлох баримтуудад тулгуурлан аймаг, нийслэл, дүүргийн татварын нэгж, харьяа нэгжийг хамруулан гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Сангийн сайдын 2018 оны 143 дугаар тушаалаар баталсан “Сангийн яамны харьяа агентлагийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-аар тодорхойлсон арга зүйгээс гадна ТЕГ-ын даргын 2020 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Татварын албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх, үр дүнг үнэлэх журам”-ийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Тайлант хугацааны үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хүрэх түвшинг бодит гүйцэтгэлтэй нь харьцуулсан хувиар;
- Тухайн нэгжийн ажил хариуцсан холбогдох албан тушаалтан, татварын улсын ахлах байцаагчидтай уулзах, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн, тогтоосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг тухайн нэгжээс гаргаж, ТБМНС-д бүртгэсэн гүйцэтгэл, тайлант хугацаанд хийж, гүйцэтгэсэн ажлын тайлан, баримт материал, нотлох зүйлд үндэслэн;
- Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийн биелэлтийн нэгдсэн үнэлгээг гаргахдаа үйл ажиллагааны чиглэл тус бүрээр гаргасан хувийг тухайн үзүүлэлтэд харгалзах итгэлцүүрээр /журмын 4 дүгээр хавсралтад дурдсан/ үржүүлэн нийлбэр оноог тооцсон;
- Аймаг, нийслэл, дүүргийн татварын нэгж, харьяа нэгжээс журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргаж, ирүүлсэн мэдээ тайлан нь татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн тоо мэдээнээс зөрүүтэй, эсхүл тухайн нэгжийн үйл ажиллагаанаас үл хамааран үйл ажиллагааны үр дүн буурч байгаа тохиолдолд тухайн газар, хэлтсийн даргын ирүүлсэн албан бичиг, ажил хариуцсан нэгжийн татварын улсын ахлах байцаагчийн тайлбар, судалгааг ТЕГ-ын холбогдох зохион байгуулалтын бүтцийн нэгжид уламжлан үндэслэлтэй гэж үзсэн асуудлуудыг үнэлгээнд харгалзан үзнэ гэж заасны дагуу татварт хамрагдуулалт, татварын тайлан хүлээн авалт, хөндлөнгийн мэдээлэл цуглуулалт, бүртгэл, ашиглалтын байдал, хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт, маргаантай актын шийдвэрлэлт зэрэг үзүүлэлтүүдийн биелэлтийн талаар харьяа албадаас ирүүлсэн тайлбарыг судалж, чиг үүргийн дагуу холбогдох бодлогын нэгжид уламжлан саналыг харгалзан үзсэн болно.
- Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн тоо, мэдээ, харьяа нэгжийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийн дагуу гаргасан тайлан, мэдээ,

тайлант хугацаанд хийж, гүйцэтгэсэн ажлын тайлан, баримт материал, тайлбар, нотлох зүйлд үндэслэн ажил хариуцсан албан хаагчидтай холбогдон зарим тодруулга, нэмэлт мэдээллийг авч ашигласан болно.

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

ТЕГ-ын даргын 2020 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Татварын албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх, үр дүнг үнэлэх журам”-ын 4 дүгээр хавсралтад дурдсан үйл ажиллагаа гүйцэтгэлийн хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийн дагуу харьяа татварын нэгжээс ирүүлсэн 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, хүрсэн үр дүн, мэдээ, тайлан, судалгаа, баримт материалд үндэслэн үйл ажиллагааны чиглэл тус бүрээр үнэлгээ өгч, нэгтгэл гаргалаа. Үүнд:

- Татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны түвшин
- Татварын орлогын гүйцэтгэл, хураалтын үйл ажиллагааны түвшин
- Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны түвшин
- Эрсдэлийн удирдлага, хөндлөнгийн мэдээлэл цуглуулалт, баталгаажуулалт, бүртгэл ба ашиглалтын үйл ажиллагааны түвшин
- Төрийн захиргаа, хууль эрхзүй, санхүүгийн үйл ажиллагааны түвшин
- Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийн түвшин
- Эрдэс баялгийн татварын хэлтсийн үйл ажиллагааны түвшин
- Мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагааны түвшин

Аймаг, нийслэл, дүүргийн татварын нэгж, харьяа нэгжийн 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийн биелэлтийн албаны дундаж үнэлгээ

Үзүүлэлтүүд		Хүрэх түвшин	Суурь түвшин		Гүйцэтгэл хувь		Итгэлцүүр тооцсон үнэлгээ
1. Татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны түвшин			60.54		68.58		10.33
1.1 Татвар төлөгчийн бүртгэлд хамруулалт		100.0					
1.2 Татвар төлөгчийн цахимаар ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэсэн байдал, сургалт		100.0	62.77		86.50		4.33
1.3 Татварын тайлан хүлээн авалтын байдал		100.0			86.40		4.32
1.4 Татварын тайлан боловсруулалт, засварласан байдал		100.0	57.18		33.31		1.69
2. Татварын орлогын гүйцэтгэл, хураалтын үйл ажиллагааны түвшин			хувь	70.65	хувь	78.13	23.68
2.1 Тайлант онд татвар төлөгчдийг татварт хамруулсан байдал		100.0	54.6	54.6	54.37	54.37	2.72
2.2. Татварын өр, ногдолын барагдуулалтын байдал				57.33		64.52	12.76
А. Урьд оны өрийн барагдуулалт	Тайлангаар ногдуулсан	төсвийн тухай хууль	44.56	90.47	53.83	97.02	3.94
	Хяналт шалгалтын актаар ногдуулсан		5.72	54.61	4.15	44.54	2.24
Б. Тайлант оны ногдуулалтын барагдуулалт	Тайлангаар ногдуулсан		67.90	62.31	58.47	70.05	2.13
	Хяналт шалгалтын актаар ногдуулсан /зөвшөөрсөн акт/		31.25	39.73	15.88	52.00	2.08
В. Татвар хураалтын үйл ажиллагаанд шат дараалсан арга хэмжээ авч ажилласан байдал		100.0		39.52		59.20	2.37
2.3. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт			100.0		81.69	92.00	88.88
3. Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны түвшин			87.33		89.95		11.69
3.1. Татварын хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт		100.0	84.83		88.87		4.30
3.2. Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны байдал		100.0	93.47		95.50		7.39
4. Хөндлөнгийн мэдээлэл цуглуулалт, баталгаажуулалт, бүртгэл ба ашиглалтын байдал			100.0	90.50	90.04		2.70
5. Төрийн захиргаа, хууль эрхзүй, санхүүгийн үйл ажиллагааны түвшин			88.19		78.99		11.91
5.1. Захиргаа, хүний нөөц, албан хаагчдын сургалттай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал		100.0	85.20		87.60		4.38
5.2. Санхүү болон үр ашигт ажиллагааны байдал		100.0	85.95		91.11		3.64

5.3. Хууль, эрхзүйн үйл ажиллагааны байдал	100.0	62.37	65.75	4.01
6. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийн түвшин	100.0	41.13	77.91	4.65
7. Эрдэс баялгийн татварын хэлтсийн үйл ажиллагааны байдал	100.0	88.19	88.92	4.45
ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭЛЦҮҮРЭЭР ТООЦСОН НИЙЛБЭР ОНОО		71.957	76.03	82.17
8. Мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлт	100.0	76.47	83.46	1.0
8.1. Дуудлагын төвийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт	100.0	96.28	93.92	1.0

Аймаг, нийслэл, дүүргийн татварын нэгж, харьяа нэгжийн 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт албадын дунджаар **76.03**, **итгэлцүүр тооцсон үнэлгээ 82.17 байна.**

“Татварын албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын 4 дугаар хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу харьяа татварын нэгжийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийн нийт дундаж үнэлгээг нэгж тус бүрээр онооны дарааллаар танилцуулбал дараах байдалтай байна.

А. Аймаг, нийслэл, дүүргийн татварын нэгж

Д/Д	Татварын албад	Оноо	Үнэлгээ
1	Архангай	83.91	*В*
2	Багануур	82.58	*В*
3	Нийслэл	82.09	*В*
4	Говь-Алтай	79.63	*С*
5	Булган	79.62	*С*
6	Дорнод	79.01	*С*
7	Өвөрхангай	78.88	*С*
8	Сүхбаатар	78.85	*С*
9	Завхан	78.80	*С*
10	Чингэлтэй	78.39	*С*
11	Дархан-Уул	78.14	*С*
12	Өмнөговь	77.91	*С*
13	Сүхбаатар дүүрэг	77.40	*С*
14	Хөвсгөл	77.29	*С*
15	Орхон	77.07	*С*
16	Сэлэнгэ	76.77	*С*

Д/Д	Татварын албад	Оноо	Үнэлгээ
17	Хэнтий	75.58	*С*
18	Увс	74.69	*С*
19	Баян-Өлгий	74.66	*С*
20	Налайх	74.45	*С*
21	Сонгинохайрхан	74.05	*С*
22	Баянхонгор	73.99	*С*
23	Баянзүрх	73.79	*С*
24	Дундговь	72.46	*С*
25	Баянгол	72.43	*С*
26	Дорноговь	72.28	*С*
27	Ховд	71.22	*С*
28	Хан-Уул	71.02	*С*
29	Говьсүмбэр	70.65	*С*
30	Төв	70.51	*С*
31	Багахангай	59.20	*Е*

Б. Татварын ерөнхий газрын харьяа нэгж:

1	МТТ	88.69	*В*	*САЙН*
2	ТТТГ	73.05	*С*	*САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ*

ХОЁР. ТАТВАР ТӨЛӨГЧДӨД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН

Татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны түвшинг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дараах 3 дэд үзүүлэлтээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд албадын дундаж 58.58 оноогоор “D” буюу “Хангалтгүй” үнэлэгдэж байна.

Үзүүлэлтүүд	Хүрэх түвшин	Гүйцэтгэл	Итгэл-цүүр	Үнэлгээ
Татвар төлөгчдийг бүртгэлд хамруулсан байдал	100.0			Үнэлээгүй
Татвар төлөгчийн цахимаар ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэсэн байдал	100.0	88.64	0.05	4.43
Татварын тайлан хүлээн авалтын байдал	80.00	79.86	0.05	3.95
Татварын тайлан боловсруулалт, засварласан байдал	100.0	33.31	0.05	1.66

2.1 ААНБ, Хувь хүнийг татвар төлөгчийн бүртгэлд хамруулсан байдал

5 бүлэг үзүүлэлтэд хамаарах 7 дэд үзүүлэлтийн мэдээлэл нь taxreport.mta.mn-д бүрэн хийгдээгүй, ТЕГ-ын 2020 оны А/162 дугаар тушаалаар “Татварын албаны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын 4-р хавсралтад тусгагдсан үзүүлэлтийг ТГҮТ-аас боловсруулж гаргаагүйгээс шалтгаалж үнэлгээ хийгдээгүй болно.

Д/Д	Үзүүлэлт	Шал гуур	Хэрэгжилтийн		Үнэлгээ
			суурь түвшин	хувь	
1	Хуулийн этгээдийг татвар төлөгчийн бүртгэлд хамруулалт, эрэн сурвалжлах үйл ажиллагаа	100			Үнэлээгүй
2	ААНОАТ төлөгчийн бүртгэлд хамруулалт	100			Үнэлээгүй
3	НӨАТ суутган төлөгчийн бүртгэл	100			Үнэлээгүй
4	Татварын төрлийн бүртгэлд хамруулалт	100			Үнэлээгүй
5	Үйл ажиллагааны орлого бүхий хувь хүнийг ХХОАТ төлөгчөөр бүртгэсэн байдал	100			Үнэлээгүй
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ					Үнэлээгүй

2.2 Татварын төлөгчийн цахимаар ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэсэн байдал

2.2.1 Татварын төлөгчийн цахимаар ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэсэн байдал /үнэлэх/

Татвар төлөгчөөс ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлт дараах байдалтай байна.

Үзүүлэлт		Татвар төлөгчийн ангилал				
		Бичил		Жижиг	Дунд	Том
		ААН	Хувь хүн	ААН	ААН	ААН
НИЙТ ИРСЭН ХҮСЭЛТИЙН ТОО	419129	161833	131641	105370	12854	7431
Хугацаандаа шийдвэрлэсэн	371526	147940	105028	99556	11980	7022
Хугацаандаа шийдвэрлээгүй	47603	13893	26613	5814	874	409
Шийдвэрлэлтийн хувь	88.64	91.42	79.78	94.48	93.20	94.50

Тайлант хугацаанд татвар төлөгчөөс 419'219 хүсэлт ирснээс 88.64 хувь буюу 371'526 хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн байна.

Татварын алба тус бүрээр хүсэлт шийдвэрлэсэн байдлыг харуулбал:

Албад	Татвар төлөгчийн ангилал					НИЙТ ирсэн хүсэлтийн тоо	Шийдвэрлэсэн хүсэлтийн тоо	Хувь
	Бичил		Жижиг	Дунд	Том			
	ААН	Хувь хүн	ААН	ААН	ААН			
Архангай	489	3987	415	46	4	4941	4130	83.59
Баян-Өлгий	1152	949	844	57	1	3003	2156	71.79
Баянхонгор	985	1754	706	44	38	3527	2803	79.47
Булган	779	2170	565	40	12	3566	2331	65.37
Говь-Алтай	1769	4750	1304	24	5	7852	6695	85.26
Дорноговь	1349	3293	1205	148	36	6031	5017	83.19
Дорнод	1126	4465	1318	182	27	7118	6065	85.21
Дундговь	573	1029	596	14	12	2224	1933	86.92
Завхан	1499	2508	863	33	4	4907	4635	94.46
Өвөрхангай	1172	6153	1101	82	25	8533	7789	91.28
Өмнөговь	2952	3811	2413	335	44	9555	8393	87.84
Сүхбаатар	563	3012	521	51	6	4153	3852	92.75
Сэлэнгэ	2431	5839	1325	43	10	9648	8140	84.37
Төв	1778	4935	1128	34	28	7903	6905	87.37
Увс	1452	3272	1106	41	15	5886	5117	86.94
Ховд	2524	2739	1713	146	19	7141	6176	86.49
Хөвсгөл	1851	5562	1534	119	10	9076	7873	86.75
Хэнтий	944	2668	1280	36	23	4951	4239	85.62
Дархан	2119	2821	1266	110	16	6332	5614	96.00
Орхон	3631	3437	2033	57	10	9168	7989	87.14
ТТГ	0	8	0	152	6161	6321	6144	97.20

НТГ	0	38	260	9206	370	9874	9534	96.56
Хан-Уул	21580	8748	11767	375	98	42568	36689	86.19
Баянзүрх	29690	15639	18271	399	62	64061	58309	91.02
Сүхбаатар дү	18626	9404	13463	310	108	41911	38081	90.86
Баянгол	23659	9851	17122	374	109	51115	48543	94.97
Багануур	1058	910	442	0	3	2413	2108	87.36
Багахангай	108	223	158	0	1	490	337	68.78
Налайх	1625	1560	1064	10	7	4266	3622	84.90
Говьсүмбэр	1002	1811	377	5	3	3198	2992	93.56
Сонгинохайхан	14960	9385	11392	202	104	36043	33665	93.40
Чингэлтэй	18387	4910	7818	179	60	31354	23650	75.43
НИЙТ	161833	131641	105370	12854	7431	419129	371526	88.64

Баян-Өлгий, Баянхонгор, Булган аймаг, Багахангай, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсүүдийн хүсэлт шийдвэрлэлт хангалтгүй байна.

2.2.2 Татвар төлөгчдөд сургалт зохион байгуулсан байдал /мэдээ/

ТУ-1.2 маягтын 2-р хэсэг болох татвар төлөгчид сургалт зохион байгуулсан байдал хэсэг нь:

- шинээр бүртгэгдсэн татвар төлөгчдийн сургалт
- татварын тайлан ирүүлдэггүй татвар төлөгчдийн сургалт
- тайлан байнга хоцроодог татвар төлөгчдийн сургалт
- татварын ногдлоо хугацаанд нь төлж хэвшээгүй татвар төлөгчдийн сургалт гэсэн 4 үзүүлэлтийг багтаадаг.

ТУНС-д өнөөдрийн байдлаар татварын албад татвар төлөгчдөд явуулсан ямар ч төрлийн сургалтыг бүртгэх, сургалтын үр дүн, чанарыг гаргах хэсэг байхгүй хэвээр байна. Татварын албадууд дээрх үйл ажиллагааг нийтлэг байдлаар /дал болсон хуучин арга барилаараа/ татвар төлөгчид татварын хуулийг сурталчлах төдийхнөөр хэрэгжүүлж байна. Татвар төлөгчдөд зориулсан сургалт зохион байгуулсан байдлын нэгтгэсэн тоо мэдээ хангалтгүй, тоон үзүүлэлтийг ТУНС-д бүртгэгдээгүй, статистик, судалгаа мэдээллийн нэгдсэн системээс гарах үзүүлэлт, судалгаа, мэдээлэлгүй тул тус хэсгийг дүгнээгүй болно.

Дүгнэлт:

1. Татварын албадууд татвар төлөгчөөс ирүүлсэн хүсэлт бүрийг шийдвэрлээгүй, шийдвэрлэх боломжгүй асуудлыг ТЕГ-ын ТТҮГ-т хандан чиглэл, дэмжлэг аваагүй, шаардлагатай тохиолдолд системд нэмэлт хөгжүүлэлт хийлгээгүй, тулгарч буй асуудлыг баримтаар явуулаагүй зэрэг уялдаа холбоогүй, хайнга ажиллаж байгаа нь татвар төлөгчөөс ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь, шаардлагатай судалгаа мэдээлэл гараагүй зэрэг байдлаас харагдаж байна.
2. Татвар төлөгчдөд явуулсан сургалтын үр дүнг тодорхойлоогүй байна.
3. ТЕГ-ТТҮГ татварын албад татвар төлөгч татварын хууль тогтоомжийн мөрдөлтийн түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн, үр дүнд суурилсан сегмент бүрээр татвар төлөгчдөд сургалтыг явуулах, татвар төлөгчдөд хийсэн сургалтыг ТУНС-д бүртгэх, үр дүнг гаргахад ач холбогдол өгч ажиллаагүй байна.

2.3 Татварын тайлан хүлээн авалтын байдал

“Татварын тайлан хүлээн авалтын мэдээ” бүлэг үзүүлэлтийг 7 дэд үзүүлэлтээр үнэлэхэд албаны хэмжээнд 79.86 хувиар “С” үнэлэгдэж байна. Үүнд:

Тайлангийн төрөл	Хүрэх түвшин	Ирцийн хувь /систем/
ААНОАТ (2023 он I, II)	80	87.63
Суутган-1 (2023 он I, II)	80	67.07
НӨАТ (2023 он 1-6 сар)	80	92.38
ОАТ (2023 он 1-6 сар)	80	98.17
Бусад татвар (2023 он I, II)	80	84.83
Төлбөр хураамж (2023 он I, II)	80	60.94
"Х" тайлангийн бууралт (2023 он II)	0.06-1	
АЛБАДЫН ДҮНДЖААР НИЙТ ҮНЭЛГЭЭ		79.86

Мэдээллийн эх сурвалж: TABLEAU мэдээллийн платформ /2023 оны 08 сарын 28, 29-ний өдрийн тоон мэдээлэл/

Суутган-1, төлбөр хураамжийн тайлангийн ирц хангалтгүй байна.

Татварын тайлан хүлээн авалтыг алба бүрээр нэгтгэн харуулбал:“

№	Татварын албад	Оноо	Үнэлгэ э
1	Булган	97.95	*А*
2	Дорнод	97.54	*А*
3	НТГ	97.16	*А*
4	ТТТГ	96.16	*А*
5	Баянхонгор	94.00	*А*
6	Увс	93.80	*А*
7	Сүхбаатар	93.69	*А*
8	Өмнөговь	93.18	*А*
9	Завхан	91.96	*А*
10	Хөвсгөл	90.91	*А*
11	Багануур	90.51	*А*
12	Дундговь	90.43	*А*
13	Хэнтий	90.29	*А*
14	Сэлэнгэ	89.73	*В*
15	Өвөрхангай	86.70	*В*
16	Дорноговь	89.15	*В*
17	Ховд	87.69	*В*

№	Татварын албад	Оноо	Үнэлгэ э
18	Орхон	86.70	*В*
19	Архангай	86.09	*В*
20	Дархан-Уул	85.48	*В*
21	Говьсүмбэр	85.23	*В*
22	Чингэлтэй	81.66	*В*
23	Багахангай	80.95	*В*
24	Говь-Алтай	79.97	*С*
25	Налайх	79.73	*С*
26	Төв	79.42	*С*
27	Хан-Уул	77.28	*С*
28	Баянгол	76.43	*С*
29	Сүхбаатар дүүрэг	75.65	*С*
30	Сонгинохайрхан	75.48	*С*
31	Баян-Өлгий	71.05	*С*
32	Баянзүрх	69.89	*Д*
Нийт		79.86	*С*

“Татварын тайлан хүлээн авалтын мэдээ” бүлэг үзүүлэлтийн үнэлгээг ААНОАТ, Суутган-1, НӨАТ, ОАТ, НХАТ, СХХООСАТ, төлбөр хураамжийн төрлөөр ангилан нэгж тус бүрээр харуулбал:

№	Татварын алба	ААНОАТ	Суутган-1	НӨАТ	ОАТ	Бусад	Төлбөр хураамж	Үнэлгээний дундаж
1	Архангай	85.26	92.33	98.74		88.80	65.31	86.09
2	Баян-Өлгий	62.87	86.02	95.50		62.40	48.47	71.05
3	Баянхонгор	85.98	94.13	99.77		94.49	95.65	94.00
4	Булган	96.15	99.26	99.95		97.86	96.51	97.95
5	Говь-Алтай	86.42	86.22	98.01	33.33	90.56	85.31	79.97
6	Дорноговь	87.95	87.95	99.18		86.47	84.22	89.15
7	Дорнод	82.68	89.49	128.66	100.00	96.00	88.40	97.54
8	Дундговь	77.09	87.27	99.59	100.00	82.58	96.02	90.43
9	Завхан	79.51	88.77	98.64	100.00	91.58	93.24	91.96
10	Өвөрхангай	90.82	94.21	99.05	100.00	83.45	70.72	89.71
11	Өмнөговь	89.15	89.64	97.72	100.00	93.29	89.29	93.18
12	Сүхбаатар	96.16	96.57	99.73		94.22	81.78	93.69
13	Сэлэнгэ	83.90	88.81	97.13		91.13	87.70	89.73
14	Төв	53.10	74.40	99.22	100.00	76.18	73.60	79.42
15	Увс	89.43	93.83	98.95	100.00	92.07	88.53	93.80
16	Ховд	94.47	86.55	97.64	100.00	74.68	72.77	87.69
17	Хөвсгөл	80.49	86.99	98.66	100.00	90.24	89.06	90.91
18	Хэнтий	84.18	90.52	98.85	100.00	86.53	81.68	90.29
19	Дархан-Уул	39.74	88.08	99.31	100.00	90.99	94.78	85.48
20	Орхон	66.40	88.94	98.35		87.51	92.31	86.70
21	ТЕГ ТТТГ	99.02		94.24	100.00		91.37	96.16
22	Нийслэл	98.42		93.88		99.17		97.16
23	Хан-Уул	67.36	66.71	90.67	100.00	84.07	54.89	77.28
24	Баянзүрх	42.67	56.69	88.55	100.00	82.35	49.07	69.89
25	Сүхбаатар дүүрэг	47.25	59.31	92.02	100.00	82.63	72.69	75.65
26	Баянгол	73.11	58.15	90.74	100.00	82.66	53.92	76.43
27	Багануур	81.13	90.97	98.90		91.06		90.51
28	Багахангай	76.25	82.31	77.24		87.99		80.95
29	Налайх	49.56	65.31	99.24		87.48	97.06	79.73
30	Говьсүмбэр	74.22	85.32	97.13		84.26		85.23
31	Сонгинохайрхан	47.39	58.20	97.63	100.00	79.55	70.14	75.48
32	Чингэлтэй	57.40	70.70	94.74	100.00	85.19	81.92	81.66
Албадын дундаж		75.80	82.79	97.43	96.49	87.01	80.23	86.62
Системийн дүн		75.75	67.08	92.38	98.17	84.83	60.94	79.86

Дээрх хүснэгтээс харахад татварын тайлан хүлээн авалт 90-98 хувьтай 13 алба /ТЕГ-ТТТГ, НТГ, Булган, Дорнод, Баянхонгор, Увс, Сүхбаатар, Өмнөговь, Завхан, Хөвсгөл, Дундговь, Хэнтий аймаг, Багануур дүүрэг/, 80-89 хувьтай 10 алба /Сэлэнгэ, Өвөрхангай, Дорноговь, Ховд, Орхон, Архангай, Дархан-Уул, Говьсүмбэр аймаг, Чингэлтэй, Багахангай дүүрэг/, 70-79 хувьтай 8 алба /Говь-Алтай, Төв, Баян-Өлгий аймаг, Налайх, Хан-Уул, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, 69.89 хувьтай 1 алба /Баянзүрх дүүрэг/ байна.

**1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн ирц /системийн дүн/
Татварын албаны хувьд ААНОАТ-ын тайлангийн ирц дараах байдалтай байна.**

Хугацаа	Ирүүлбэл зохих	Ирүүлсэн	Ирцийн хувь
2022 оны I	237	232	97.89
2022 оны II	158'113	84'775	53.62
Албадын дундаж			75.80

2019 оны 03 сарын 22-ны өдрийн “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу улирал бүр тайлагнах босгыг давсан 237 татвар төлөгч байгаа бөгөөд 2023 оны I-р улирлын тайланг 232 татвар төлөгч /том сегмент/ ирүүлж ирц 97.89 хувь, II-р улирлын тайланг 84'775 татвар төлөгч ирүүлж, тайлангийн ирц 53.62 хувьтай ба албаны дунджаар 75.80 хувьтай байна.

Татварын албаны хувьд ААНОАТ-ын тайлангийн ирцийг сегмент тус бүрээр танилцуулбал дараах байдалтай байна.

Сегмент	2023 оны I-р улирал	2023 оны II-р улирал	Ирцийн дундаж хувь
Бичил /Micro/	50	38	44.4
Жижиг /Small/	75	96	85.5
Дунд /Medium/	100	97	98.5
Том /Big/	99.4	97.6	99.0

Бичил сегментэд ирц 44.4 хувь буюу хамгийн бага, том сегментэд 99.0 хувь буюу хамгийн өндөр байна.

2. “Суутган-1” татварын тайлангийн ирц /системийн дүн/

Татварын албаны хувьд Суутган-1-ийн тайлангийн ирц дараах байдалтай байна.

Хугацаа	Ирүүлбэл зохих	Ирүүлсэн	Ирцийн хувь
2023 оны I	225'311	154'844	68.7
2023 оны II	229'394	150'116	65.4
Дундаж			67.1

Татварын албаны хувьд Суутган-1 татварын тайлангийн ирцийг сегмент тус бүрээр танилцуулбал дараах байдалтай байна.

Хугацаа	Бичил /Micro/	Жижиг /Small/	Дунд /Medium/
2023 оны I	61	97	95
2023 оны II	57	96	95
Дундаж	59.3	96.8	95.2

Системийн дүнгээр бичил сегментийн тайлангийн “Суутган-1”-ын ирц дундаж 67.1 хувь буюу хамгийн бага, шалгуур хангаагүй үзүүлэлттэй байна.

3. Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангийн ирц /системийн дүн/

Татварын бүртгэл мэдээллийн сан, цахим тайлангийн системийн мэдээгээр татварын албадын НӨАТ-ын тайлангийн 2023 оны 1-6 дугаар сарын ирцийн дундаж үзүүлэлтийг тооцсон.

Үзүүлэлт	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар
Ирүүлбэл зохих	55,956	56,172	56,083	56,307	56,901	57,922
Ирүүлсэн	52,336	51,823	51,808	52,276	52,443	52,787
Ирцийн хувь	93.5	92.2	92.3	92.8	92.1	91.1
Дундаж	92.38					

Системийн хэмжээний НӨАТ-ын тайлангийн ирцийн дундаж 92.38 хувь байна. НӨАТ-ын тайланд “Х” тайлангийн эзлэх дундаж хувь 18.53 байна. Тайлангийн ирцийг сегмент тус бүрээр харуулбал:

Сегмент	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	Дундаж
Бичил /Micro/	86.3	83.8	84.0	84.1	83.1	81.8	83.84
Жижиг /Small/	98.7	98.2	98.2	98.3	97.9	97.2	98.08
Дунд /Medium/	90.9	90.7	91.4	97.6	97.7	98.0	94.39
Том /Big/	89.3	89.3	91.3	99.0	99.1	99.0	94.53

4. Онцгой албан татварын тайлангийн ирц /системийн дүн/

Онцгой албан татварын 2023 оны тайлангийн ирцийг 2023 оны 08 сарын 28-ны өдөр TABLEAU тоон мэдээллийн программаас татаж нэгтгэхэд 1-6 дугаар сарын тайлангийн ирцийн дундаж **98.17** хувийн гүйцэтгэлтэй байна.

Ирүүлбэл зохих	Ирүүлсэн	Х тайлан	Ирцийн хувь	Х тайлангийн хувь
218	214	73	98.17	34.11

5. Бусад татварын тайлан хүлээн авалт /системийн дүн/

Бусад татварын тайлан хүлээн авалтын шалгуур үзүүлэлтэд журамд заасны дагуу нийслэл хотын албан татвар, Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын тайлангийн ирцийг хамруулахаар тусгасан.

Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын тайлангийн ирцийн дундаж **82.83** хувь, Нийслэл хотын албан татварын тайлангийн ирцийн дундаж **86.83** хувьтай байна.

Д/Д	Татварын төрөл	Хүрэх түвшин	Ирцийн дундаж хувь
1	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын тайлан	80	82.83
2	Нийслэл хотын албан татварын тайлан	80	86.83
Дундаж			84.83

Дээрх хүснэгтээс харахад системийн хэмжээнд тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

7. Төлбөр, хураамжийн тайлангийн ирц /системийн дүн/

Энэхүү үзүүлэлтэд байгалийн баялаг ашиглахтай холбоотой төлбөр, хураамжаас гадна ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, улсын тэмдэгтийн хураамж, ус бохирдуулсны төлбөр, агаарын бохирдлын төлбөрийн тайлангийн ирцийг хамруулан үнэлэхээр ХШҮ-ний журамд тусгасан. Төлбөр хураамжийн тайлангийн ирцийн дундаж үзүүлэлт дараах байдалтай байна.

Д/Д	Татварын төрөл	Ирцийн дундаж хувь
1	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан	85.13
2	Агаарын бохирдлын төлбөрийн тайлан /Олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах төлбөр/	2.56
3	Ус бохирдуулсны төлбөрийн тайлан	77.36
4	Улсын тэмдэгтийн хураамжийн тайлан	78.71
Дундаж үзүүлэлт		60.94

Төлбөр хураамжийн тайлангийн ирцийн албадын дундаж 60.94 хувьтай байна.

Дүгнэлт:

1. Бичил сегментийн татвар төлөгчдийн тайлангийн ирц бусад сегментийн тайлангийн ирцээс хамгийн бага байгаа нь энэ ангиллын татвар төлөгчдийн зан төлөв, хууль тогтоомж мөрдөлт төлөвшөөгүй, хэрэгжүүлж буй арга хэмжээ нь тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

2. Агаарын бохирдлын төлбөрийн тайлан /Олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах төлбөр/-ийн тайлангийн ирц хангалтгүй буюу 2.56 хувьтай байгаа нь төлбөр, хураамжийн төрлөөр бүртгэлтэй татвар төлөгчдийг тайлан ирүүлэх талаар авч буй ажиллагаа, бүртгэлийн баазыг цэгцлэх ажил орхигдсоныг харуулж байна. ТЕГ-ын ТТҮГ нь нийт татвар төлөгчийн бүртгэлийн баазыг цэгцлэх, татварын төрлөөс хасах ажлыг холбогдох журмын дагуу тогтмол зохион байгуулах, удирдлага арга зүйгээр хангах, гүйцэтгэлд хяналт тавих ажлыг зохих түвшинд хийх, харьяа нэгжүүд холбогдох зохион байгуулалтын нэгжээс ирүүлсэн үүрэг даалгавар, чиглэлийг хэрэгжүүлэх талаар хангалттай ажиллагаа хийхгүй байгааг илтгэж байна.

3. Татварын албадын тайлангийн ирцийн мэдээлэл нь TABLEAU мэдээллийн платформ болон Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн татварын тайлан ирүүлсэн татвар төлөгчдийн жагсаалтаас зөрүүтэй, ажил хариуцсан ТЕГ-ын зохин байгуулалтын нэгж мэдээллийн үнэн зөв байдлыг хангахтай холбоотой ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4. Татварын тайлан хүлээн авалтын үед татварын төлөгчийн татварын тайлан давхардаж илгээгдэх, тухайн алдаатай илгээгдсэн тайланг систем хүлээж авсан байна. Алдаатай тайлан илгээгдсэн, хүлээн авсан байдлыг ТТҮГ, ТЕГ-МТТ, ГТСМТТ УҮГ шалгаж алдааны мэдээллийг тодруулах, засварлах ажил хийгдээгүй байна.

2.4 Татварын тайлан боловсруулалт, зөрчилтэй тайлан засварлуулсан байдал

ТЕГ-ын даргын 2020 оны А/18 “Татварын ерөнхий газрын харьяа нэгжийн бүтэц, чиг үүргийг батлах тухай” тушаалаар батлагдсан Татвар төлөгчтэй харилцах асуудал хариуцсан /сегментийн/ нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэгт тусгагдсан “Татварын тайлан хүлээн авах, тайлангийн боловсруулалт хийх, залруулсан тайланг хүлээн авах, залруулаагүй тохиолдол холбогдох нэгжид шилжүүлэх...” чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлыг, харьяа нэгжээс ирүүлсэн мэдээ тайлан, гүйцэтгэл, түүний нотлох баримтад үндэслэн тайлангийн шалгуураар татвар төлөгчид буцаагдсан тайланг залруулан хүлээн авсан байдал, залруулаагүй тайланг холбогдох нэгжид шилжүүлэн ажиллагаа хийгдсэн байдал гэсэн 2 үзүүлэлтээр хяналт шинжилгээ үнэлгээ хийхээр журамлагдсан. 2023 оны эхний хагас жилд тайлангийн шалгуураар татвар төлөгчид буцаагдсан тайланг залруулан хүлээн авсан байдал гэсэн үзүүлэлтэд ХШҮ хийсэн ба албаны хэмжээнд 33.31 оноогоор “Маш муу” гэж үнэлэгдэж байна.

ТЕГ-ын ТТҮГ, ЭУГ нь дээрх ажлын зураглалыг бүрэн гаргаагүй, программын хөгжүүлэлтийг шийдвэрлээгүйгээс нийт албаны хэмжээнд ажиллагаа бүрэн хийгдээгүй, хийгдсэн ажиллагааны мэдээлэл харуулах шийдэл байхгүй тул 2023 онд энэ үзүүлэлтийг нийт буцаагдсан тайлангаас залруулан хүлээж авсан тайлангийн хувь үзүүлэлтээр үнэлгээ хийх, үнэлгээний суурь өгөгдөлд судалгаа мэдээллийн TABLEAU системийн мэдээллийг ашиглахаар шийдвэрлэсэн. Татвар төлөгчид буцаагдсан тайланг залруулан хүлээн авсан байдлыг татварын төрлөөр харуулбал:

№	Татварын төрөл	Нийт буцаагдсан	Залруулан хүлээж авсан	Залруулаагүй хүлээн авсан	Залруулаагүй хүлээгдэж буй	Залруулан хүлээж авсан хувь	Залруулаагүй хүлээн авсан хувь	Хүлээгдэж буй хувь
1	НӨАТ	18467	14582	2417	1468	78.96	13.09	7.95
2	ААНОАТ	58251	30263	11664	16324	51.95	20.02	28.02
3	ХХОАТ	117743	19658	64462	33623	16.70	54.75	28.56
Нийт		194461	64503	78543	51415	33.17	40.39	26.44

Мэдээллийн эх үүсвэр: Судалгаа, мэдээллийн TABLEAU систем /ТУ-1.4 мэдээ, 2023-08-30/

Дээрх хүснэгтээс харахад ААНОАТ-ын тайлан /2022 оны 4 дүгээр улирал, 2023 оны оны 1-2 улирал/, НӨАТ-ын тайлан /2023 оны 1-6 сар/, ХХОАТ-ын тайлан /2022 он/-гийн төрлүүдээр тайлангийн шалгуураар буцаагдсан, тэдгээрээс залруулан хүлээн авсан, залруулаагүй хүлээн авсан байдлыг албан тус бүрээр авч үзэхэд нийт албаны хэмжээнд 194'461 тайлан шалгуур хангаагүй хэмээн буцаагдаж үүнээс 78'543 тайланг залруулаагүй хүлээн авсан /40.39 хувь/, 64'503 тайланг залруулан хүлээж авсан /33.17 хувь/ байна.

ХХОАТ-ын төрлөөр залруулаагүй хүлээн авсан тайлангийн хувь өндөр байгаа нь тайлангийн шалгуурт татагддаг бусад тайлангийн үзүүлэлтүүдийн боловсруулалт дуусаагүй байхад ТТ-06 тайлан гаргадаг байдалтай холбоотой ба шалгуурыг боловсронгуй болгох, энэ төрлийн тайлан хүлээн авах хугацааг бусад төрлийн тайлангийн хугацаанаас хойшлуулан зөрүүлэх боломжийг судлах шаардлагатай байгааг харуулж байна. Татвар төлөгчид буцаагдсан тайланг залруулан хүлээн авсан байдлыг татварын албадаар харуулбал:

№	Алба	Нийт	Залруулан хүлээн авсан	Залруулаагүй хүлээн авсан	Залруулаагүй хүлээгдэж буй	Залруулсан хувь	Залруулаагүй хүлээн авсан хувь
1	Архангай	5749	637	2772	2340	11.08	48.22
2	Баян-Өлгий	3559	361	2734	464	10.14	76.82
3	Баянхонгор	7247	877	3988	2382	12.10	55.03
4	Булган	11129	3744	4984	2401	33.64	44.78
5	Говь-Алтай	5099	1839	456	2804	36.07	8.94
6	Дорноговь	3625	794	1734	1097	21.90	47.83
7	Дорнод	3333	897	1291	1145	26.91	38.73
8	Дундговь	2904	1312	50	1542	45.18	1.72
9	Завхан	2794	1237	658	899	44.27	23.55
10	Өвөрхангай	3619	1066	843	1710	29.46	23.29
11	Өмнөговь	4351	2249	466	1636	51.69	10.71
12	Сүхбаатар	2156	674	881	601	31.26	40.86
13	Сэлэнгэ	4913	2152	349	2412	43.80	7.10
14	Төв	3725	1207	819	1699	32.40	21.99
15	Увс	6008	1814	3204	990	30.19	53.33
16	Ховд	4986	850	3158	978	17.05	63.34
17	Хөвсгөл	7914	1414	5528	972	17.87	69.85
18	Хэнтий	4632	1120	1274	2238	24.18	27.50

19	Дархан-Уул	3989	1263	2086	640	31.66	52.29
20	Орхон	5612	1432	3637	543	25.52	64.81
21	ТТТГ	1387	458	650	279	33.02	46.86
22	Нийслэл	3140	2148	580	412	68.41	18.47
23	Хан-Уул	13872	5287	4432	4153	38.11	31.95
24	Баянзүрх	22703	7743	10481	4479	34.11	46.17
25	Сүхбаатар дүүрэг	13486	5867	4204	3415	43.50	31.17
26	Баянгол	17011	5544	7796	3671	32.59	45.83
27	Багануур	1886	1223	226	437	64.85	11.98
28	Багахангай	583	245	30	308	42.02	5.15
29	Налайх	1420	377	742	301	26.55	52.25
32	Говьсүмбэр	841	208	494	139	24.73	58.74
34	Сонгинохайрхан	11469	4580	4510	2379	39.93	39.32
35	Чингэлтэй	9319	3884	3486	1949	41.68	37.41
Системийн дүн		194461	64503	78543	51415	33.17	40.39
Албадын дундаж						33.31	37.69

Мэдээллийн эх үүсвэр: Судалгаа, мэдээллийн TABLEAU систем /ТУ-1.4 мэдээ, 2023-08-30/

Дээрх хүснэгтээс харахад НТГ, Багануур дүүрэг татвар төлөгчид буцаагдсан тайлангийн 64.85-68.41 хувийг залруулан хүлээн авсан бусад татварын албадад 11.08-51.69 хувийг залруулан хүлээн авсан нь маш хангалтгүй байна.

Нийт буцаагдсан тайлангийн 49.51 хувь, залруулан хүлээн авсан тайлангийн 57.91, залруулаагүй хүлээн авсан тайлангийн 47.28 хувь, залруулах шаардлагатай хүлээгдэж буй тайлангийн 42.37 хувь нь нийслэл дэх албадад ногдож байна.

	Татварын алба	Нийт	Залруулан хүлээж авсан	Залруулаагүй хүлээн авсан	Залруулаагүй	Залруулсан хувь	Залруулаагүй хүлээн авсан хувь
21	ТТТГ	1387	458	650	279	33.02	46.86
22	НТГ	3140	2148	580	412	68.41	18.47
23	Хан-Уул	13872	5287	4432	4153	38.11	31.95
24	Баянзүрх	22703	7743	10481	4479	34.11	46.17
25	Сүхбаатар дүүрэг	13486	5867	4204	3415	43.50	31.17
26	Баянгол	17011	5544	7796	3671	32.59	45.83
27	Багануур	1886	1223	226	437	64.85	11.98
28	Багахангай	583	245	30	308	42.02	5.15
29	Налайх	1420	377	742	301	26.55	52.25
34	Сонгинохайрхан	11469	4580	4510	2379	39.93	39.32
35	Чингэлтэй	9319	3884	3486	1949	41.68	37.41
Нийслэл дэх албад		96276	37356	37137	21783		
Системийн дүн		194461	64503	78543	51415		
		49.51	57.91	47.28	42.37		

Мэдээллийн эх үүсвэр: Судалгаа, мэдээллийн TABLEAU систем /ТУ-1.4 мэдээ, 2023-08-30/

Дүгнэлт:

- Тайлангийн шалгуураар буцаагдсан нийт тайлангийн 49.51 хувь, засварлаагүй хүлээн авсан тайлангийн 47.28 хувь, хүлээгдэж буй тайлангийн 42.37 хувь нь нийслэл дэх албадад ногдож байгаагаас харвал эдгээр албадад тайлан засварлах үйл ажиллагааг журамд нийцүүлэн эрчимжүүлснээр нийт албаны хэмжээнд энэ үзүүлэлт эрс сайжрах боломжтойг харуулж байна.
- Залруулаагүй төлөвт байгаа 51415 тайлангийн асуудлыг хуулийн хугацаа дуусахаас өмнө шийдвэрлэх шаардлагатай.

ГУРАВ. ТАТВАРЫН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, ХУРААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН

Татварын орлогын гүйцэтгэл, хураалтын үйл ажиллагааны түвшинг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийхэд системийн дундаж **78.13** оноогоор “С” буюу “Сайжруулалт хэрэгтэй” үнэлгээтэй үнэлэгдэж байна.

Үзүүлэлтүүд	Хүрэх түвшин	Гүйцэтгэл	Албадын дундаж	Итгэлцүүр	Үнэлгээ
-------------	--------------	-----------	----------------	-----------	---------

3.2.1 Тайлант онд татвар төлөгчдийг татварт хамруулсан байдал	100	54.37	54.37	0.05	2.72	
3.2.2 Татварын өр, ногдлын барагдуулалтын түвшин			64.52	0.16	12.76	
А. Урьд оны өрийн барагдуулалт	Тайлангаар ногдуулсан	30	53.83	97.02	0.04	3.94
	Хяналт шалгалтын актаар ногдуулсан	25	4.15	44.54	0.05	2.24
Б. Тайлант оны ногдуулалтын	Тайлангаар ногдуулсан	80	58.47	70.05	0.03	2.13
	Хяналт шалгалтын актаар ногдуулсан /зөвшөөрсөн акт/	60	15.88	52.00	0.04	2.37
В. Татвар хураалтын үйл ажиллагаанд шат дараалсан арга хэмжээ авч,				0.04	2.37	
3.2.3 Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт	100	92.00	88.88	0.09	8.00	
ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭЛЦҮҮРЭЭР ТООЦСОН НИЙЛБЭР ОНОО				78.13		

3.1 Тайлант онд татвар төлөгчдийг татварт хамруулсан байдал

ТЕГ-ын харьяа нэгжийн 2023 оны эхний хагас жилд татвар төлөгчийг татварт хамруулсан үйл ажиллагааг сегментэд ангилагдсан ангиллаар батлагдсан журмын хүрээнд 9 дэд үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд системийн хэмжээнд дунджаар **54.35** оноогоор “Е” буюу “Маш муу” үнэлгээтэй үнэлэгдэж, тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна.

Татвар төлөгчдийг татварт хамруулсан байдлыг татварын төрөл, сегмент тус бүрээр ангилан харуулбал:

Үзүүлэлт	НИЙТ	Үүнээс: Сегментийн ангиллаар				
		Бичил	Жижиг	Дунд	Том	
1.НӨАТ төлөгчийг татварт хамруулалт	Ногдолтой	38721	10689	25520	1885	627
	Буцаан олголтоор тайлант оны ногдлыг хасан	11047	3363	6979	562	143
	Хамруулбал зохих	27674	7326	18541	1323	484
	Татварын ногдол төлсөн	11622	2285	8023	896	418
	Гүйцэтгэлийн хувь	42.00	31.19	43.27	67.72	86.36
3.Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татвар төлөгчийг татварт хамруулалт	Тайлангаарх ногдолтой	50652	16257	31018	2590	787
	Татвар төлсөн	32877	8981	21240	2032	624
	Гүйцэтгэлийн хувь	64.91	55.24	68.48	78.46	79.29
5.ҮХЭХАТ-г хамруулалт	Бүртгэлтэй	77454	57119	13648	4244	2443
	Татвар төлсөн	23296	10776	9445	1964	1111
	Гүйцэтгэлийн хувь	30.08	18.87	69.20	46.28	45.48
6.АТБӨЯХАТ-г хамруулалт	Бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо	1204914	940096	133977	103615	27226
	Татвар төлсөн тээврийн хэрэгслийн тоо	675622	506877	75400	75136	18209
	Гүйцэтгэлийн хувь	56.07	53.92	56.28	72.51	66.88
7.Галт зэвсгийн албан татварт	Бүртгэлтэй	26635	25898	567	110	60
	Татвар төлсөн	10237	9709	394	94	40
	Гүйцэтгэлийн хувь	38.43	37.49	69.49	85.45	66.67
8.Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварт	Тайлангаарх ногдолтой	2068	376	1318	245	129
	Татвар төлсөн	1423	248	926	156	93
	Гүйцэтгэлийн хувь	68.81	65.96	70.26	63.67	72.09
9.Онцгой албан татварын татварт	Тайлангаарх ногдолтой	39	2	12	15	10
	Татвар төлсөн	31	0	10	12	9
	Гүйцэтгэлийн хувь	79.49	0.00	83.33	80.00	90.00
10.Нийслэл хотын албан татварын татварт	Тайлангаарх ногдолтой	3242	1007	2133	88	14
	Татвар төлсөн	1817	485	1252	67	13
	Гүйцэтгэлийн хувь	56.05	48.16	58.70	76.14	92.86
11.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр татвар төлөгчийг татварт	Тайлангаарх ногдолтой	106	8	21	12	65
	Татвар төлсөн	83	5	10	8	60
	Гүйцэтгэлийн хувь	78.30	62.50	47.62	66.67	92.31
Нийт	Хамруулбал зохих	1392784	1048089	201235	112242	31218
	Татварын ногдол төлсөн	757008	539366	116700	80365	20577
	Гүйцэтгэлийн хувь	54.35	51.46	57.99	71.60	65.91

Татварт хамрагдвал зохих 9 дэд үзүүлэлтээс АМНАТ, ОАТ 78.30-79.49 хувиар “Сайжруулалт хэрэгтэй”, ЦХХТАОАТ, СХХООСАТ 64.91-68.81 хувиар “Хангалтгүй”, НӨАТ, НХАТ, ҮХЭХАТ, АТБӨЯХАТ, ГЗАТ 30.08-56.07 хувиар “Маш муу” гэсэн үнэлгээгээр тус тус үнэлэгдэж байна.

Том сегментэд ангилагдсан татвар төлөгчийг 65.91 хувь дунд сегментэд ангилагдсан татвар төлөгчийг 71.60 хувь, бичил болон жижиг сегментэд ангилагдсан татвар төлөгчийг 51.46-57.99 хувийг татварт хамруулсан байна.

Татварт хамруулбал зохих татвар төлөгчийн 75.25 хувийг бичил /бичил-иргэн/ ангилагдсан татвар төлөгч эзэлж тус ангиллын татвар төлөгчийн 51.46 хувийг татварт хамруулсан байна.

Нийт татварт хамрагдсан 757'008 татвар төлөгчийн 89.25 хувь нь буюу 675'622 АТБӨЯХАТ төлөгч эзэлж байна.

Татварт хамрагдалтыг нийт дүнгээр болон татварын албадаар харуулбал:

д/д	Татварын алба	Хамрагдах	Хамрагдсан	Хувь	д/д	Татварын алба	Хамрагдах	Хамрагдсан	Хувь
		Татвар төлөгчийн тоо					Татвар төлөгчийн тоо		
1	Архангай	24059	12694	52.76	17	Нийслэл	2767	1926	69.61
2	Багануур	9967	5708	57.27	18	Орхон	38653	22734	58.82
3	Багахангай	1275	734	57.57	19	Өвөрхангай	36215	17456	48.20
4	Баянгол	136201	78318	57.50	20	Өмнөговь	70024	51162	73.06
5	Баянзүрх	190876	104083	54.53	21	Сонгинохайрхан	125033	64700	51.75
6	Баян-Өлгий	29619	10203	34.45	22	Сүхбаатар	21989	12074	54.91
7	Баянхонгор	26289	12599	47.92	23	Сүхбаатар дүүрэг	113635	62438	54.95
8	Булган	20677	11444	55.35	24	Сэлэнгэ	37125	18990	51.15
9	Говь-Алтай	20349	10323	50.73	25	ТТТГ	579	490	84.63
10	Говьсүмбэр	5372	2575	47.93	27	Төв	29272	15083	51.53
11	Дархан-Уул	36277	18252	50.31	28	Увс	23802	10806	45.40
12	Дорноговь	30532	16760	54.89	29	Хан-Уул	109753	63481	57.84
13	Дорнод	23483	12647	53.86	30	Ховд	30050	14657	48.78
14	Дундговь	15899	8566	53.88	31	Хөвсгөл	40172	19356	48.18
15	Завхан	22722	11509	50.65	32	Хэнтий	23760	12498	52.60
16	Налайх	11915	6446	54.10	32	Чингэлтэй	84443	46296	54.83

Системийн хэмжээнд 29 алба татвар төлөгчдийн 34.45-58.86 хувийг татварт хамруулж тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна.

Татварт хамрагдсан байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал дараах байдалтай байна.

№	Татварын төрөл	Хамрагдвал зохих татвар төлөгчийн тоо				Хамрагдсан татвар төлөгчийн тоо				Гүйцэтгэлийн хувь		
		2022	2023	Өсөлт/+, бууралт -/	Хувь	2022	2023	Өсөлт/+, бууралт -/	Хувь	2022	2023	Өсөлт/+, бууралт -/
		II улирал										
1	НӨАТ	22174	27674	5500	12.44	9147	11622	2475	17.21	41.25	42.00	0.75
2	ЦХХТАОАТ	43263	50652	7389	30.91	26302	32877	6575	136.42	60.8	64.91	4.11
3	ҮХЭХАТ	59040	77454	18414	1.09	42184	23296	-18888	-3.12	71.45	30.08	-41.37
4	АТБӨЯХАТ	857146	1204914	347768	-8.57	549259	675622	126363	4.79	64.08	56.07	-8.01
5	ГЗАТ	28458	26635	-1823	3.56	9459	10237	778	-44.55	33.24	38.43	5.19
6	СХХООСТ	1536	2068	532	-44.91	1135	1423	288	-30.5	73.89	68.81	-5.08
7	ОАТ	56	39	-17	47.37	45	31	-14	28.57	80.36	79.49	-0.87
8	НХАТ	3086	3242	156	-8.67	1408	1817	409	-41.6	45.63	56.05	10.42
9	АМНАТ	56	106	50	-56.92	26	83	57	-63.89	46.43	78.30	31.87
Нийт		1427286	1392784	-34502	10.34	768166	757008	-11158	6.94	53.82	54.35	0.53

/ААНОАТ-ыг оруулж тооцоогүй/ Татварт хамрагдвал зохих татвар төлөгчийн тоо татварын төрлөөр 2, хамрагдсан татвар төлөгчийн тоо татварын 5 төрлөөр нэмэгдэж бусад татварын төрлөөр буурсан байна.

Сегментэд ангилагдсан татвар төлөгчдийг татварт хамруулсан байдлыг албаар, сегментийн ангилал бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах байдалтай байна.

д/д	Татварын алба	II Татварын төрлийн гүйцэтгэлийн дундаж хувь				д/д	Татварын алба	II Татварын төрлийн гүйцэтгэлийн дундаж хувь			
		Сегментийн ангилалаар						Сегментийн ангилалаар			
		Бичил	Жижиг	Дунд	Том			Бичил	Жижиг	Дунд	Том
1	Архангай	51.56	70.53	63.61	56.10	18	Орхон	57.01	64.80	73.52	77.64
2	Багануур	55.83	65.90	59.10	74.53	19	Өвөрхангай	46.13	59.24	78.32	63.49
3	Багахангай	57.10	61.02		42.86	20	Өмнөговь	63.77	82.56	81.71	86.18
4	Баянгол	55.63	56.17	68.08	71.18	21	Сонгинохайрхан	51.05	50.69	58.32	63.94
5	Баянзүрх	52.83	53.73	70.38	56.20	22	Сүхбаатар	53.31	67.66	75.45	68.57

6	Баян-Өлгий	33.78	40.32	67.80	30.59
7	Баянхонгор	46.26	60.46	67.96	42.97
8	Булган	54.92	60.04	84.29	44.94
9	Говь-Алтай	49.91	59.32	77.27	54.93
10	Говьсүмбэр	44.82	62.99	62.50	64.29
11	Дархан-Уул	48.47	57.89	72.93	43.27
12	Дорноговь	52.08	64.20	77.35	58.85
13	Дорнод	50.83	68.65	69.43	49.77
14	Дундговь	52.81	61.18	74.05	60.53
15	Завхан	50.06	56.23	83.72	80.80
16	Налайх	52.68	69.14	59.18	27.42
17	Нийслэл	72.74	67.38	67.27	90.24

23	Сүхбаатар дүүрэг	51.24	56.70	67.33	51.55
24	Сэлэнгэ	48.29	64.83	83.25	79.75
25	Том татвар төлөгчийн газар		60.00	100.00	84.94
26	Төв	51.08	54.15	61.29	68.13
27	Увс	43.54	61.46	55.11	44.79
28	Хан-Уул	54.37	57.26	74.00	77.37
29	Сонгинохайрхан	47.5	47.2	52.4	64.6
30	Сүхбаатар дү.	56.7	48.2	57.7	46.6
31	Хан-Уул	50.6	53.8	67.5	78.2
32	Чингэлтэй	53.8	50.4	70.7	55.7
НИЙТ		51.46	57.99	71.60	65.91

Бичил сегмент: Татвар төлөгчдийг татварт хамруулсан үйл ажиллагааг 9 дэд үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд татварын төрлөөр бүртгэгдсэн 1'048'089 татвар төлөгчөөс 539'366 татвар төлөгчийг татварт хамруулсан байна. НӨАТ-ын бичил сегментэд ангилагдсан татвар төлөгчдийн татварт хамрагдалтыг 2023 оны эхний 6 сарын байдлаар НӨАТ-ын тайлангаарх ногдолтой 10'689 татвар төлөгчдөөс НӨАТ-ын буцаан олголтоор тайлант оны ногдлыг хаасан 3'363 татвар төлөгчийг хасаж тооцсон. Бичил сегментэд ангилагдсан татвар төлөгчдийг татварт хамруулбал зохих 9 дэд үзүүлэлтээс 2 үзүүлэлт буюу , АМНАТ, СХХООСТ 62.50-65.96 хувиар “Хангалтгүй”, бусад 7 үзүүлэлт буюу ЦХХТАОСАТ, НХАТ, ГЗАТ, НӨАТ, ОАТ, АТБӨЯХАТ, ОАТ 0.0-55.24 хувиар “Маш муу”, албаны хэмжээнд 51.46 буюу “Маш муу” гэсэн үнэлгээгээр тус тус үнэлэгдсэн ба татварын албад тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна. Нийт татварын албадаас НТГ 72.74 хувиар “Сайжруулалт хэрэгтэй”, Өмнөговь аймаг 63.77 оноогоор “Хангалтгүй”, бусад 29 татварын албад 33.78- 57.10 оноогоор “Маш муу” гэж үнэлэгдэж байна.

Жижиг сегмент: Татвар төлөгчдийг татварт хамруулсан үйл ажиллагааг 9 дэд үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд татварын төрлөөр бүртгэгдсэн 201'235 татвар төлөгчөөс 116'700 татвар төлөгчийг татварт хамруулсан байна.

Татварын төрөлд бүртгэгдсэн жижиг сегментэд ангилагдсан татвар төлөгчдийг татварт хамруулбал зохих 9 дэд үзүүлэлтээс ОАТ 83.33 оноогоор “Сайн”, СХХООСАТ 70.26 хувиар “Сайжруулалт хэрэгтэй”, ЦХХТАОСАТ, ГЗАТ, ҮХЭХАТ 69.20-69.49 оноогоор “Хангалтгүй”, 4 үзүүлэлт буюу АМНАТ, НӨАТ, НХАТ, АТБӨЯХАТ 43.27-58.70 оноогоор “Маш муу” гэж үнэлэгдлээ.

Татварын албадаас Өмнөговь аймаг 82.56 оноогоор “Сайн”, Хэнтий, Архангай аймаг 70.53-73.63 хувиар “Сайжруулалт хэрэгтэй”, Налайх, Багахангай, Багануур дүүрэг, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Дорноговь, Говьсүмбэр, Увс, Дундговь, Баянхонгор, Булган аймаг, Нийслэл, Том татвар төлөгчийн газар 60.04- 69.14 оноогоор “Хангалтгүй”, бусад 15 татварын албад 40.32-59.31 оноогоор “Маш муу”, үнэлэгдэж байна.

Дунд сегмент: Татвар төлөгчдийг татварт хамруулсан үйл ажиллагааг 9 дэд үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд татварын төрлөөр бүртгэгдсэн 112'242 татвар төлөгчөөс 80'365 татвар төлөгчийг татварт хамруулсан байна.

Татварын төрөлд бүртгэгдсэн дунд сегментэд ангилагдсан татвар төлөгчдийг татварт хамруулбал зохих 9 дэд үзүүлэлтээс 2 үзүүлэлт буюу ОАТ, ГЗАТ 80.00-85.45 оноогоор “Сайн”, 3 үзүүлэлт буюу ЦХХТАОСАТ, АТБӨЯХАТ, НХАТ 72.51-78.46 оноогоор “Сайжруулалт хэрэгтэй”, 3 үзүүлэлт буюу НӨАТ, СХХООСАТ, АМНАТ 63.67-67.72 хувиар “Хангалтгүй”, ҮХЭХАТ, 46.28 хувиар “Маш муу”, албаны хэмжээнд 71.60 хувь буюу “Сайжруулалт хэрэгтэй” гэсэн үнэлгээгээр үнэлэгдэж байна. Татварын албадаас Хэнтий аймаг, Том татвар төлөгчийн газар 90.91-100 оноогоор “Маш сайн”, Булган, Завхан, Сэлэнгэ, Өмнөговь аймаг 81.71-84.29 оноогоор “Сайн”, Өвөрхангай, Ховд, Дорноговь, Говь-Алтай, Хөвсгөл, Сүхбаатар, Дундговь, Орхон, Дархан-Уул аймаг, Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх дүүрэг 70.38- 78.32 оноогоор “Сайжруулалт хэрэгтэй”, Дорнод, Баянхонгор, Баян-Өлгий, Архангай, Говьсүмбэр, Төв аймаг, Нийслэл, Баянгол, Сүхбаатар дүүрэг 61.29-69.43 оноогоор “Хангалтгүй”, бусад 4 татварын албад 55.11-59.18 оноогоор “Маш муу” гэж үнэлэгдлээ.

Том сегмент: Татвар төлөгчдийг татварт хамруулсан үйл ажиллагааг 9 дэд үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд татварын төрлөөр бүртгэгдсэн 31'218 татвар төлөгчөөс 20'577 татвар төлөгчийг татварт хамруулсан байна.

Татварын төрөлд бүртгэгдсэн том сегментэд ангилагдсан татвар төлөгчдийг татварт хамруулбал зохих 9 дэд үзүүлэлтээс 3 үзүүлэлт буюу ОАТ, НХАТ, АМНАТ 90.0-92.86 оноогоор “Маш сайн”, НӨАТ 86.36 оноогоор “Сайн”, 2 үзүүлэлт буюу СХХООСАТ, ЦХХТАОСАТ 72.09-79.29 оноогоор “Сайжруулалт хэрэгтэй”, 2 үзүүлэлт буюу АТБӨЯХАТ, ГЗАТ 66.67-67.88 оноогоор “Хангалтгүй”,

ҮХЭХАТ 45.48 хувиар “Маш муу”, албаны хэмжээнд 65.91 хувь буюу “Хангалтгүй” үнэлэгдлээ. Татварын албадаас Нийслэл 90.24 оноогоор “Маш сайн”, Том татвар төлөгчийн газар, Өмнөговь, Завхан аймаг 80.80-8 86.18 оноогоор “Сайн”, Сэлэнгэ, Орхон аймаг, Хан-Уул, Багануур, Баянгол дүүрэг 71.18-79.75 оноогоор “Сайжруулалт хэрэгтэй”, Хэнтий, Сүхбаатар, Төв, Говьсүмбэр, Өвөрхангай, Дундговь аймаг, Сонгинохайрхан, дүүрэг 60.53-69.60 оноогоор “Хангалтгүй”, бусад 16 татварын албад 27.42-58.85 оноогоор “Маш муу” гэж үнэлэгдсэн.

Дүгнэлт:

1. Тайлант хугацаанд хамрагдвал зохих болон хамрагдсан татвар төлөгчийн тоо өнгөрсөн онтой харьцуулахад буурсан ч хамрагдалт 0.53 хувиар өссөн байна.
2. Жижиг, дунд, том сегментэд ангилагдсан татвар төлөгчийн татварт хамруулсан байдал өнгөрсөн жилтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байгаа нь цар тахлын дараах тус ангиллын татвар төлөгчдийн үйл ажиллагаа сэргэх хандлагатай байгааг харуулж байна.
3. Хөрөнгийн татвар буюу ҮХЭХАТ, АТБӨЯХАТ, СХХООСАТ-г хамрагдсан татвар төлөгчийн тоо буурсан үзүүлэлттэй байгаа нь ажил хариуцсан албан хаагчийн үйл ажиллагаатай хамааралтай гэж үзэхээр байна.
4. Татварт хамруулбал зохих нийт татвар төлөгчийн 75.25 хувийг бичил /бичил-иргэн/ сегментэд ангилагдсан татвар төлөгч эзэлж байгаагаас 51.46 хувийг, хамруулбал зохих татвар төлөгчийн 14.45 хувийг жижиг сегментэд ангилагдсан татвар төлөгч эзэлж байгаагаас 57.99 хувийг татварт хамруулсан байгаа нь албад тус сегментийн хамрагдалтад анхаарах шаардлагатайг харуулж байна. taxreport.mta.mn-д татварт хамрагдсан болон хамрагдаагүй татвар төлөгчийн судалгаа дэлгэрэнгүй болон нэгтгэл хэлбэрээр гарч байгаа ч ажил хариуцсан албан хаагч, ахлах байцаагчид судалгааг үйл ажиллагаандаа ашиглахгүй, хяналт тавихгүй байна. Цаашид татварт хамрагдаагүй татвар төлөгчийн судалгаанд үндэслэн татвар төлөгчийг татварт хамруулах ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

3.2 Татварын өр, ногдлын барагдуулалтын түвшин

Татвар хураалтын түвшин үйл ажиллагааг дараах хоёр үзүүлэлтээр сегментийн ангилал тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд албадын дунджаар **64.52** оноогоор **“D”** буюу **“Хангалтгүй”** үнэлэгдэж байна.

Татварын өрийн барагдуулалт үзүүлэлтийн тоон мэдээг ТХУАЗГ-аас 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн тоон мэдээ, харьяа албадын өдөр ирүүлсэн тоон мэдээллүүд, тайлбар тодруулгуудыг харьцуулан үзэж үнэлгээ хийсэн.

Үнэлгээг хийхдээ системийн болон албадын дунджаар тооцсон.

3.2. А. Урьд оны татварын өрийн барагдуулалт

Татвар хураалтын түвшин үйл ажиллагааг дараах хоёр үзүүлэлтээр сегментийн ангилал тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үзүүлэлттэй байна.

- Урьд оны тайлангаар ногдуулсан өр 5,981.77 тэрбум төгрөгийн өрийн 53.83 хувь буюу 3,219.95 тэрбум төгрөг;

- Хяналт шалгалтын актаар ногдуулсан 1,294.91 тэрбум төгрөгийн өрийн 4.15 хувь буюу 53.71 тэрбум төгрөгийг тайлант онд барагдуулсан байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд урьд оны тайлангийн өрийг 60.0 хувиар барагдуулсан байх шалгуур үзүүлэлттэй боловч эхний хагас жилийн байдлаар дүгнэж байгаа тул итгэлцүүрийг 30.0 хувиар тооцоход урьд оны тайлангийн ногдлын өрийн барагдуулалт шалгуур үзүүлэлтээр системийн дунджаар 100.0, албадын дунджаар 97.02 оноогоор, хяналт шалгалтын актын урьд оны өрийн барагдуулалтыг албадын дүнгээр 50.0 хувиар барагдуулсан байх шалгуур үзүүлэлттэй боловч эхний хагас жилийн байдлаар итгэлцүүрийг 25.0 хувиар тооцоход системийн дунджаар 9.63, албадын дунджаар 44.54 оноогоор оноогоор тус тус үнэлэгдэж байна.

Урьд оны татварын өрийн барагдуулалт:

Үзүүлэлт		Нийт дүн /сая төгрөгөөр/	Үүнээс: Сегментийн ангилал /сая төгрөг/				
			Бичил	Хувь хүн	Жижиг	Дунд	Том
Төлбөл зохих	Нийт дүн	6,785,259.37	589,003.82	267,284.31	1,527,244.95	725,481.50	3,676,244.79
	Үүнээс: Тайлангаар ногдуулсан	488,409.18	257,923.83	1,432,531.72	654,249.70	3,136,528.40	1,779,003.75

		Хяналт шалгалтын актаар ногдуулсан	100,594.64	9,360.48	94,713.23	71,231.80	539,716.39	473,393.62
Барагдуулалт	Нийт дүн		3,273,663.89	58,985.47	43,744.92	558,738.08	328,835.50	2,283,359.91
	Үүнээс:	Тайлангаар ногдуулсан	57,286.49	42,785.52	548,721.47	315,218.94	2,255,937.31	968,901.05
		Хяналт шалгалтын актаар ногдуулсан	1,698.98	959.40	10,016.60	13,616.56	27,422.60	16,175.22
Эцсийн үлдэгдэл	Нийт дүн		3,511,595.48	530,018.35	223,539.39	968,506.87	396,645.99	1,392,884.88
	Үүнээс:	Тайлангаар ногдуулсан	2,749,693.08	431,122.69	215,138.30	883,810.24	339,030.76	880,591.08
		Хяналт шалгалтын актаар ногдуулсан	761,902.40	98,895.66	8,401.08	84,696.63	57,615.23	512,293.79

Бичил сегмент: Татварын албаны хэмжээнд бичил сегментэд хамаарах татвар төлөгчийн урьд оны тайлангаарх 488,409.18 сая төгрөгийн татварын өрөөс 57,286.49 сая төгрөг буюу 11.73 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 39.10 оноогоор, урьд оны хяналт шалгалтын 100,594.64 сая төгрөгийн татварын өрөөс 1,698.98 сая төгрөг буюу 1.69 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 6.76 оноогоор үнэлэгдэж байна. Шалгуур үзүүлэлтээр урьд оны өрийн барагдуулалт НТГ, Увс, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Ховд, Баянхонгор, Дорнод, Дархан-Уул, Төв, Орхон, Хэнтий, Дундговь Баян-Өлгий, Сэлэнгэ, Өвөрхангай аймаг, Баянзүрх, Сүхбаатар Баянгол, Чингэлтэй, Багахангай, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг хангалтгүй үнэлгээтэй байна.

Хувь иргэн: Татварын албаны хэмжээнд бичил сегментэд хамаарах татвар төлөгчийн урьд оны тайлангаарх 257,923.83 сая төгрөгийн татварын өрөөс 42,785.52 сая төгрөг буюу 16.59 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 55.30 оноогоор, урьд оны хяналт шалгалтын 9,360.48 сая төгрөгийн татварын өрөөс 959.40 сая төгрөг буюу 10.25 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 41.0 оноогоор үнэлэгдэж байна. Шалгуур үзүүлэлтээр урьд оны өрийн барагдуулалт НТГ, Чингэлтэй, Баянгол, Багануур, Багахангай, Сонгинохайрхан, Налайх дүүрэг, Дорноговь, Говь-Алтай, Хэнтий, Архангай, Орхон, Булган, Өвөрхангай, Дундговь, Төв, Өмнөговь, Завхан, Сүхбаатар, Баянхонгор, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дархан-Уул, Баян-Өлгий аймаг хангалтгүй үнэлгээтэй байна.

Жижиг сегмент Татварын албаны хэмжээнд жижиг сегментэд хамаарах татвар төлөгчийн урьд оны тайлангаарх 1,432,531.72 сая төгрөгийн татварын өрөөс 548,721.47 сая төгрөг буюу 38.30 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтийг хангасан, урьд оны хяналт шалгалтын 94,713.23 сая төгрөгийн татварын өрөөс 10,016.60 сая төгрөг буюу 10.58 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 42.3 оноогоор үнэлэгдэж байна. Шалгуур үзүүлэлтээр Баянгол, Баянзүрх, Чингэлтэй Сонгинохайрхан, Хан-Уул, Сүхбаатар дүүрэг, НТГ, Төв, Баян-Өлгий, Ховд, Өмнөговь, Дундговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Хэнтий, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгууд урьд оны хяналт шалгалтын өрийн барагдалт хангалтгүй үнэлгээтэй байна.

Дунд сегмент: Татварын албаны хэмжээнд дунд сегментэд хамаарах татвар төлөгчийн урьд оны тайлангаарх 654,249.70 сая төгрөгийн татварын өрөөс 315,218.94 сая төгрөг буюу 48.18 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтийг хангасан, урьд оны хяналт шалгалтын 71,231.80 сая төгрөгийн татварын өрөөс 13,616.56 сая төгрөг буюу 19.12 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 76.46 оноогоор үнэлэгдэж байна.

Том сегмент: Татварын албаны хэмжээнд том сегментэд хамаарах татвар төлөгчийн урьд оны тайлангаарх 3,136,528.40 сая төгрөгийн татварын өрөөс 2,255,937.31 сая төгрөг буюу 71.92 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтийг хангасан, урьд оны хяналт шалгалтын 539,716.39 сая төгрөгийн татварын өрөөс 27,422.60 сая төгрөг буюу 5.08 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 20.32 оноогоор үнэлэгдэж байна.

Дүгнэлт:

1. Программ дээр өр давхардсан, татвар төлөгчийн алдаанаас шалтгаалсан хэт их оронтой тоогоор өр үүсэх, төлбөрийн нэхэмжлэл устахгүй байх, төлөлт банкны жагсаалт, тооцоололд үүсэхгүй зэрэг алдаанууд гарсаар байна.

2. Төсвийн тухай хуульд өр барагдуулалтын шалгуурын хувь хэмжээ тайлангаар ногдуулсан өрийн барагдуулалт 60 хувь, хяналт шалгалтаар ногдуулсан өрийн барагдуулалт 50 хувь болж буурсан болон хагас жилийн ажил дүгнэсэн үзүүлэлтийг 30 хувь, 25 хувиар тооцсоноос шалтгаалж албадын урьд оны тайлангаар болон хяналт шалгалтаар ногдуулсан өрийн барагдуулалтын үзүүлэлт өссөн мэт харагдаж байгаа боловч бодит байдалд өр барагдуулалт муу байна.

3.2. Б. Тайлант хугацаанд ногдуулсан татварын өрийн барагдуулалт

2023 оны эхний хагас жилийн байдлаар тайлангаар ногдуулсан 3,660.47 тэрбум төгрөгийн 58.47 хувь буюу 2,140.21 тэрбум төгрөг, хяналт шалгалтын актаар ногдуулсан 196.33 тэрбум төгрөгийн 15.88 хувь буюу 31.18 тэрбум төгрөгийг барагдуулсан байна.

Төсвийн тухай хуульд тайлангийн ногдлыг 80.0, хяналт шалгалтын актаар ногдуулсан барагдуулалтыг системийн дүнгээр 60.0 хувиар барагдуулсан байх шалгуур үзүүлэлтийг баталсан бөгөөд тайлангийн ногдлын барагдуулалт шалгуур үзүүлэлтээр тооцоход системийн дунджаар 73.08, албадын дунджаар 70.05 оноогоор, хяналт шалгалтаар ногдуулсан ногдлын барагдалт системийн дунджаар 26.47 оноогоор, албадын дунджаар 52.00 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

ТАЙЛАНТ ОНЫ ӨРИЙН БАРАГДУУЛАЛТ :

/сая төгрөг/

Үзүүлэлт		Нийт дүн /сая төгрөг/	Үүнээс: Сегментийн ангилал /сая төгрөг/				
			Бичил	Хувь хүн	Жижиг	Дунд	Том
Төлбөл зохих татвар	Нийт дүн	3,856,805.20	151,498.10	179,584.41	897,255.32	314,652.32	2,313,815.06
	Үүнээс: Тайлангаар ногдуулсан	3,660,474.27	148,246.40	177,294.74	865,429.52	286,866.48	2,182,637.12
	ХШ-ын актаар ногдуулсан	196,330.93	3,251.69	2,289.67	31,825.80	27,785.83	131,177.94
Бараг- дуулсан	Нийт дүн	2,171,395.54	50,519.06	90,726.74	505,001.22	191,135.50	1,334,013.03
	Үүнээс: Тайлангаар ногдуулсан	2,140,216.92	49,801.40	90,215.87	493,830.36	179,987.59	1,326,381.71
	ХШ-ын актаар ногдуулсан	31,178.62	717.66	510.87	11,170.86	11,147.91	7,631.32
Эцсийн ногдол	Нийт дүн	1,685,409.66	100,979.04	88,857.67	392,254.10	123,516.81	979,802.03
	Үүнээс: Тайлангаар ногдуулсан	1,520,257.35	98,445.01	87,078.87	371,599.16	106,878.89	856,255.41
	ХШ-ын актаар ногдуулсан	165,152.31	2,534.03	1,778.80	20,654.94	16,637.92	123,546.62

Бичил сегмент: Татварын албаны хэмжээнд бичил сегментэд хамаарах татвар төлөгчийн тайлангаар ногдуулсан 148,246.40 сая төгрөгийн татварын ногдлоос 49,801.40 сая төгрөг буюу 33.59 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 41.99 оноогоор, хяналт шалгалтын актаар ногдуулсан 3,251.69 сая төгрөгийн ногдлоос 717.66 сая төгрөг буюу 22.07 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 36.78 оноогоор үнэлэгдэж байна. Тайлангийн ногдлын болон хяналт шалгалтын актаар ногдуулсан ногдлын барагдуулалт Том татвар төлөгчийн газар, Багануур дүүрэг, Говь-Алтай, Дархан-Уул, Баянхонгор, Говьсүмбэр аймаг 6 татварын албанаас бусад алба хангалтгүй оноогоор үнэлэгдэж байна.

Хувь иргэн: Татварын албаны хэмжээнд бичил иргэний сегментийн татвар төлөгчийн тайлангаар ногдуулсан 177,294.74 сая төгрөгийн татварын ногдлоос 90,215.87 сая төгрөг буюу 50.88 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 63.61 оноогоор, хяналт шалгалтын актаар ногдуулсан 2,289.67 сая төгрөгийн ногдлоос 510.87 сая төгрөг буюу 22.31 хувийг барагдуулан 37.19 оноогоор үнэлэгдэж байна. Тайлангийн ногдлын болон хяналт шалгалтын актаар ногдуулсан ногдлын барагдуулалт Төв, Сүхбаатар, Булган, Баянхонгор, Багахангай, Ховд, Дархан-Уул, Өмнөговь, Баянзүрх, Өвөрхангай, Увс, Сэлэнгэ, Завхан, Налайх, Сүхбаатар дүүрэг, Баян-Өлгий, Хан-Уул татварын албад хангалтгүй оноогоор үнэлэгдэж байна.

Жижиг сегмент: Татварын албаны хэмжээнд жижиг сегментийн татвар төлөгчийн 865,429.52 сая төгрөгийн тайлангийн ногдлоос 493,830.36 сая төгрөг буюу 57.06 хувийг барагдуулан 71.33 оноогоор, хяналт шалгалтын актаар ногдуулсан 31,825.80 сая төгрөгөөс 20,654.94 сая төгрөг буюу 35.10 хувийг барагдуулан 58.50 оноогоор үнэлэгдэж байна. Тайлангийн ногдлын болон хяналт шалгалтын актаар ногдуулсан өрийн Хэнтий, Дархан-Уул, Баянхонгор, Хан-Уул, Говь-Алтай, Говьсүмбэр, Ховд, Баянгол, Булган, Хөвсгөл, Сонгинохайрхан, Багануур, Орхон, Баянзүрх, Өвөрхангай, Төв аймгийн татварын албад хангалтгүй оноогоор үнэлэгдэж байна.

Дунд сегмент: Татварын албаны хэмжээнд дунд сегментийн татвар төлөгчийн 286,866.48 сая төгрөгийн тайлангийн ногдлоос 179,987.59 сая төгрөг буюу 62.74 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 78.43 оноогоор, хяналт шалгалтын актаар ногдуулсан 27,785.83 сая төгрөгийн ногдлоос 11,147.91 сая төгрөг буюу 40.12 хувийг барагдуулж шалгуур үзүүлэлтээр 66.87 оноогоор үнэлэгдэж байна.

Том сегмент: Татварын албаны хэмжээнд том сегментийн татвар төлөгчийн 2,182,637.12 сая төгрөгийн тайлангийн ногдлоос 1,326,381.71 сая төгрөг буюу 60.77 хувийг барагдуулан шалгуур үзүүлэлтээр 75.96 оноогоор, хяналт шалгалтын актаар ногдуулсан 131,177.94 сая төгрөгийн

ногдлоос 7,631.32 сая төгрөг буюу 5.82 хувийг барагдуулж шалгуур үзүүлэлтээр 9.70 оноогоор үнэлэгдэж байна.

Дүгнэлт:

Тайлант оны тайлангаар ногдуулсан ногдлын барагдуулалт 58.47 хувь буюу шалгуур үзүүлэлтээр 73.09 оноогоор хангалтгүй, Хяналт шалгалтын ногдлын барагдалт 15.88 хувь буюу шалгуур үзүүлэлтээр 26.47 оноогоор маш муу үнэлэгдэж байгаа нь үлдсэн хугацаанд татварын ногдлыг хугацаандаа барагдуулах, өр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

3.2. В. Татвар хураалтын үйл ажиллагаанд шат дараалсан арга хэмжээ авч ажилласан байдал

Татвар хураалтын үйл ажиллагаанд шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал үзүүлэлтийг taxreport.mta.gov.mn программд бүртгэсэн татварын нэгжийн тоон үзүүлэлт, албадаас ирүүлсэн шат дараалсан арга хэмжээний мэдээ, ТХУАЗГ-аас ирүүлсэн тоон мэдээлэл зэргийг үндэслэн үнэлгээ хийсэн. Татвар хураалтын үйл ажиллагаанд шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал үзүүлэлт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 59.20 оноогоор үнэлэгдэж байна.

Үзүүлэлт		Нийт	Үүнээс:				Шалгуур үзүүлэлт	Хувь	Үнэлгээ
			Бичил	Жижиг	Дунд	Том			
Үл маргах журмаар гаргуулах, харилцах дансны зарлагын гүйлгээг хаах нэхэмжлэлийг банкинд хүргүүлж ажилласан байдал	Нэхэмжлэл хүргүүлсэн татвар төлөгч	19'550	12'076	6'963	423	88	70	22.03	31.47
	Харилцах дансны зарлагын гүйлгээг хаасан татвар төлөгч	4'306	2'436	1'709	132	29			
Өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг тогтоосон байдал	Харилцах дансны зарлагын гүйлгээг хаасан боловч төлбөр төлөгдөөгүй татвар төлөгч	1'595	1'066	460	59	10	100	99.19	99.19
	Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд	3	-	3	-	-			
	Тогтоовол зохих татвар төлөгч	1'598	1'066	463	59	10			
	Тогтоосон татвар төлөгч	1'585	1'064	453	59	9			
Өртэй татвар төлөгчийн эрхийг хязгаарлах, түдгэлзүүлсэн байдал	Түдгэлзүүлбэл зохих татвар төлөгч	21	19	1		1	100	100	100
	Түдгэлзүүлсэн татвар төлөгч	21	19	1		1			
Хөрөнгө болон авлага битүүмжилсэн байдал	Битүүмжилбэл зохих татвар төлөгч	41	13	27		1	30	12.58	41.94
	Битүүмжилсэн татвар төлөгч	41	13	27		1			
Битүүмжилсэн хөрөнгийг хураах, дуудлага худалдаа зохион байгуулсан байдал	Зохион байгуулбал зохих	2		2			30	50.00	100
	Зохион байгуулсан	1		1					
ШШГА-аас хүлээн авсан болон шүүхэд байгаа татвар төлөгчийн өрийн барагдуулалтын байдал	Өртэй татвар төлөгч	274	234	36	4		20	32.12	100
	Төсөвт орсон орлогын	88	63	22	3				
НИЙТ ҮНЭЛГЭЭ									59.20

Татвар хураалтын үйл ажиллагаанд шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдлыг 6 үзүүлэлтээр үнэлгээ хийсэн ба татварын алба тус бүрээр үнэлгээг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Д/Д	Татварын алба	Үнэлгээ
1	Архангай	69.79
2	Баян-Өлгий	76.32
3	Баянхонгор	24.22
4	Булган	85.46
5	Говь-Алтай	84.64

Д/Д	Татварын алба	Үнэлгээ
17	Хөвсгөл	50.73
18	Хэнтий	57.31
19	Дархан-Уул	86.11
20	Орхон	85.41
21	ТТТГ	88.43

6	Дорноговь	40.46
7	Дорнод	33.87
8	Дундговь	38.94
9	Завхан	47.88
10	Өвөрхангай	89.31
11	Өмнөговь	57.33
12	Сүхбаатар	10.20
13	Сэлэнгэ	54.79
14	Төв	32.72
15	Увс	24.12
16	Ховд	57.68

22	Нийслэл	74.94
23	Хан-Уул	37.49
24	Баянзүрх	81.16
25	Сүхбаатар	71.50
26	Баянгол	40.27
27	Багануур	84.46
28	Багахангай	21.98
29	Налайх	75.00
30	Говьсүмбэр	53.83
31	Сонгинохайрхан	73.68
32	Чингэлтэй	84.43
Нийт үнэлгээ		59.20

Хан-Уул дүүрэг, Баянгол, Налайх дүүрэг, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий аймгийн татварын хэлтэс нь хөрөнгө болон авлага битүүмжилсэн байдал үзүүлэлтэд “0” үнэлгээгээр үнэлэгдсэн бол НТГазар, Булган, Говь-Алтай, Өмнөговь, Хөвсгөл аймгийн татварын хэлтэс нь “50.00” үнэлгээгээр тус тус үнэлэгдсэн.

Дүгнэлт:

1. Татвар хураалтын үйл ажиллагаанд шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал үзүүлэлт нь системийн хэмжээгээр хангалтгүй байгаа нь ажил хариуцсан албан хаагч, түүний үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий нэгжийн дарга нар татвар төлөгч бүртэй ажиллахгүй, ялангуяа төсвийн орлогод нөлөө багатай татварын төрлүүдийг орхигдуулдагтай холбоотойг харуулж байна.

2. Хан-Уул дүүрэг, Баянгол, Налайх дүүрэг, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий аймгийн татварын хэлтэс нь хөрөнгө болон авлага битүүмжлэх арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байгаад ТЕГ-ын ТХУАЗГ-аас хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллах нь зүйтэй байна.

3.3 Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт

Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт үзүүлэлтийг журмын дагуу харьяа татварын нэгжийн 2023 оны эхний хагас жилийн байдлаар улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт, жигд ажиллагааны түвшин гэсэн 2 дэд үзүүлэлтээр үнэлэхэд албадын хэмжээнд системийн дунджаар **92.00** оноогоор “**А**” буюу “**Маш сайн**”, албадын дунджаар **88.88** оноогоор “**В**” буюу “**Сайн**” үнэлгээгээр дүгнэгдэж байна.

Журамд татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сар бүрийн өссөн дүнгээр тооцох ба тус үзүүлэлтийн дундаж үнэлгээг тооцоходоо төлөвлөгөөний биелэлтийг 70.0, жигд ажиллагааны түвшинг 30.0 хувиар тооцохоор тусгасан. Харьяа татварын нэгжийн хувьд 2023 оны эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний орлогын биелэлтийг дараах байдалтайгаар биелүүлсэн байна.

Үүнд:

/сая төгрөг/

Төсвийн орлого		Улсын төсөв	Аймаг, нийслэлийн	Сум, дүүргийн	Нийт	Хувь
А.Төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөгөө	3,935,428.25	485,459.14	976,635.30	5,397,522.69	100.00
	Гүйцэтгэл	4,806,079.39	591,460.90	1,106,370.75	6,503,911.05	
	Хувь	100.00	100.00	100.00	100.00	
Б.Жигд ажиллагааны түвшин	Биелүүлэх сар	6	6	6	6	73.33
	Биелүүлсэн сар	6	4	4	4.4	
НИЙТ ҮНЭЛГЭЭ						92.0

Харьяа татварын албадын 2023 оны эхний хагас жилийн байдлаар татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн дундаж 100.00 хувьтай, жигд ажиллагааны түвшин үзүүлэлтээр 73.33 хувьтай үнэлэгдэж байна.

Харьяа нэгжийн 2023 оны эхний хагас жилийн байдлаарх улс, аймаг, нийслэл, орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн байдлыг татварын албадаар нь харуулбал:

Д/Д	Татварын албад	Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь	Д/Д	Татварын албад	Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь
-----	----------------	---	-----	----------------	---

		Улс	Аймаг нийслэл	Орон нутаг
1	Архангай	128.39	156.47	100.04
2	Баян-Өлгий	110.33	170.54	106.83
3	Булган	144.74	113.31	100.45
4	Баянхонгор	121.88	114.70	87.01
5	Говь-Алтай	130.89	267.59	115.61
6	Дорноговь	183.84	191.94	116.34
7	Дундговь	150.11	176.32	106.94
8	Дорнод	168.68	155.87	110.75
9	Завхан	108.69	64.64	129.86
10	Өвөрхангай	96.88	157.69	113.04
11	Өмнөговь	191.37	135.63	243.06
12	Сүхбаатар	180.68	146.54	92.38
13	Сэлэнгэ	169.35	132.41	123.85
14	Төв	127.92	177.64	123.55
15	Увс	111.11	146.46	91.19
16	Ховд	160.52	200.58	110.22
17	Хөвсгөл	131.20	132.07	112.48

		Улс	Аймаг нийслэл	Орон нутаг
18	Хэнтий	124.91	166.17	122.58
19	Дархан-Уул	104.50	124.23	122.12
20	Орхон	119.33	121.51	100.27
21	Говьсүмбэр	155.10	139.08	115.69
22	Сүхбаатар дүүрэг	152.35	109.44	101.45
23	Баянзүрх	129.74	86.09	77.71
24	Багануур	127.59	81.40	111.28
25	Чингэлтэй	142.24	94.94	101.85
26	Сонгинохайрхан	133.63	88.11	103.69
27	Хан-Уул	164.18	89.01	113.30
28	Налайх	116.68	101.93	104.37
29	Баянгол	138.25	89.05	106.50
30	Багахангай	90.71	51.73	158.05
31	Нийслэл	125.90	110.91	
32	ТТТГ	130.42		
НИЙТ ДҮН		131.2	121.8	112.7

Улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт: Багахангай дүүрэг, Өвөрхангай аймаг, 90.71-96.88 хувь буюу 85.15-90.47 сая төгрөгөөр дутуу, бусад 30 татварын алба 104.50-128.39 хувиар төлөвлөгөөг биелүүлсэн байна.

Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт: Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Багануур, Багахангай дүүрэг, Завхан аймаг гэх 8 татварын алба 51.73-94.94 хувь буюу 484.88-27,336.71 сая төгрөгөөр дутуу, бусад 23 татварын алба 101.93-156.47 хувиар биелүүлсэн байна.

Сум, дүүргийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт: Баянзүрх дүүрэг, Сүхбаатар, Увс, Баянхонгор аймаг зэрэг 4 татварын алба 77.71-92.38 хувь буюу 87.1-958.25 сая төгрөгөөр давуулан, бусад 26 татварын алба 100.26-243.06 хувиар биелүүлсэн байна.

Дүгнэлт:

1. Албадын хэмжээнд татварын орлогын төлөвлөгөө 90.55-169.12 хувийн гүйцэтгэлтэй хэдий ч аймаг, нийслэл, дүүргийн албадын жигд ажиллагаа 44.44-78.89 хувьтай байгаа нь албад татварын орлогын төлөвлөгөөг төсөв, татварын төрлөөр сар бүр жигд ханган биелүүлэхгүй байгааг харуулж байна.

2. Харьяа татварын албад татварын орлогын төлөвлөгөөний хуваарийг сар бүр жигд хуваарилах, ТУНС-д үнэн зөв бүртгэх, биелэлтэд сар бүр хяналт тавьж ажиллах шаардлагатай.

3. Татварын орлогын төлөвлөгөө сегментээр ангилагдахгүй байгаа нь албад сегмент тус бүрээр орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлээ хянаж, шинжилгээ хийн ажлаа төлөвлөхөд хүндрэлтэй байна.

ДӨРӨВ. ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН

Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны түвшинг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэлийн хувийг тооцоход системийн дүн 87.986 оноо **“В”** буюу **“Сайн”** байна.

2023 онд хяналт шалгалтын төлөвлөгөө 1 дүгээр улирал болон бусад гэж 2 хуваагдаж батлагдсан. ТХШ-ыг эрсдэлд суурилсан байдлаар зохион байгуулсан учир сар бүрийн жигд ажиллагааны үзүүлэлтийг үнэлээгүй.

Үзүүлэлтүүд		Хүрэх түвшин	Гүйцэтгэл	Итгэл-цүүр	Үнэлгээ
4.1. Татварын хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт	Систем	100.0	79.245	0.05	3.96
	Албадын дундаж		88.874		
4.2. Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны байдал	Систем	100.0	96.727	0.08	7.74
	Албадын дундаж		94.355		
СИСТЕМИЙН ДҮН					87.986

Бүлэг үзүүлэлтийн гүйцэтгэлийн хувийг албадаар толилуулбал дараах байдалтай байна:

Д/Д	Татварын алба	ТУ-3		
		ТУ-3.1	ТУ-3.2	Дундаж
1	Архангай	100.000	90.476	95.238
2	Баян өлгий	100.000	97.952	98.976
3	Баянхонгор	91.176	82.230	86.703
4	Булган	76.920	95.896	86.408

5	Говь алтай	90.000	96.162	93.081
6	Дорноговь	100.000	100.000	100.000
7	Дорнод	100.000	95.238	97.619
8	Дундговь	100.000	100.000	100.000
9	Завхан	100.000	100.000	100.000
10	Өвөрхангай	100.000	100.000	100.000
11	Өмнөговь	81.957	92.561	87.259
12	Сүхбаатар	100.000	100.000	100.000
13	Сэлэнгэ	100.000	96.296	98.148
14	Төв	77.778	92.024	84.901
15	Увс	88.235	98.529	93.382
16	Ховд	100.000	96.780	98.390
17	Хөвсгөл	90.625	98.828	94.727
18	Хэнтий	100.000	85.714	92.857
19	Дархан уул	96.970	99.609	98.290
20	Орхон	93.571	91.903	92.737
21	ТТТГ	41.584	91.516	66.550
22	Нийслэл	64.100	92.741	78.421
23	Хан уул	90.000	98.399	94.199
24	Баянзүрх	72.810	94.130	83.470
25	Сүхбаатар	81.200	93.521	87.360
26	Баянгол	91.300	91.129	91.215
27	Багануур	97.222	100.000	98.611
28	Багахангай			
29	Налайх	90.000	98.889	94.444
32	Говьсүмбэр			
34	Сонгинохайрхан	81.940	98.100	90.020
35	Чингэлтэй	68.830	96.481	82.656
Албадын дундаж дүн		88.874	95.504	92.189

4. 1. Татварын хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт

Харьяа татварын нэгжийн 2023 оны хагас жилийн татварын хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлтийн үзүүлэлтийг эрсдэл тооцож, томилолт үүсгэсэн хяналт шалгалтын ажлын гүйцэтгэлийн хувиар нэгжээс ирүүлсэн гүйцэтгэлийн мэдээ, ТХШАЗГ-ын нэгтгэл мэдээ болон ТУНС, taxreport.mta.mn системийн мэдээлэлд үндэслэн тулган шалгахад системийн дүнгээрх гүйцэтгэлийн хувь 79.245, албадын дундаж 88.874 хувь байна.

Дүгнэлт:

1. ТТТГ, НТГ-ын нэг татвар төлөгчийн хяналт шалгалтад ногдох хүн өдөр цөөн хоног байгаагаас татварын хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байна.
2. Дүүрэг орон нутгийн татварын албаны ХШ-нд хамрагдах татвар төлөгчийн тоо цөөрсөнтэй холбоотойгоор хяналт шалгалтад бүрэн хамруулсан байдал харьцангуй сайн байна.
3. Говьсүмбэр аймгийн татварын хэлтэст Татварын хяналт шалгалтын ажил хийгдээгүй нь хүний нөөцийн дутагдалтай холбоотой байна.

4. 2 Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны байдал:

Харьяа татварын нэгжийн 2023 оны хагас жилийн татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны үзүүлэлтийг батлагдсан 8 үзүүлэлтийн дунджаар тооцоход системийн хэмжээнд 96.73, албадын дундаж 95.50 буюу “Маш сайн” үнэлэгдэж байна.

д/д	Үзүүлэлт	Үнэлгээ
1	Тайлант онд татварын улсын байцаагчийн үйлдсэн шийдвэрийн байдал	94.81
2	Хяналт шалгалт хийх томилолт олгосон байдал	79.13
3	Татварын албаны эрсдэлийн үнэлгээг баталгаажуулсан байдал	99.68
4	Онцгой албан татварын тухай хууль, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн хэрэгжилтэд хийх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан байдал	99.70
5	НӨАТ-ын илүү үлдэгдлийг баталгаажуулах хүсэлт ирүүлсэн татвар төлөгчдийг шалгаж баталгаажуулсан байдал	100.00
6	Татварын хяналт шалгалт хийж төлүүлэхээр шийдвэрлэсэн, зөвшөөрсөн маргаангүй татварын акт, илтгэх хуудсыг шилжүүлсэн байдал	99.12
7	Маргаантай актын шийдвэрлэлтийн байдал	89.72

8	Хяналт шалгалтад хамрагдсан татвар төлөгчдөөс хөндлөнгийн мэдээлэл цуглуулсан байдал	100.00
9	Хяналт шалгалтын үр дүнгээр гарсан түгээмэл зөрчлийг үйл ажиллагааны чиглэлээр тодорхойлон эрсдэлээс сэргийлэх сургалт зохион байгуулах.	100.00
Нийт үнэлгээ		96.73

“Хяналт шалгалт хийх томилолт олгосон байдал” үзүүлэлт системийн хэмжээнд 79.13 байгаа нь татварын хяналт шалгалтыг томилолтын хугацаанд дуусгахгүй байгаагаас хангалтгүй үнэлэгдлээ.

Урд оны 106, тайлант онд гарсан 38, нийт 145 маргаантай актаас 2023 оны 06 сарын 30-ны байдлаар 42 актыг эцэслэн шийдвэрлэж 103 актын шийдвэрлэлт хүлээгдэж байна.

Дүгнэлт:

1. Хяналт шалгалтад хамрагдсан татвар төлөгчийн эрсдэлийн үнэлгээг хэрхэн баталгаажуулсан нь тодорхойгүй. Эрсдэлийн үнэлгээтэй татвар төлөгчид зөрчилгүй гэж үзэн илтгэх хуудас бичсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ бодит эсэхэд өгсөн үнэлгээ байхгүй, ТУНС-д энэ мэдээллийн оруулах талбар байхгүй.

2. ЭУГ, ХШАЗГ-аас хяналт шалгалт хийгдсэн татвар төлөгчдөөс чанар хангасан хөндлөнгийн мэдээллийг хэдийг, хэрхэн цуглуулах тоо, хязгаарыг тогтоосон чиглэл зааварчилгаа өгөөгүй.

3. Харьяа албад ТУ мэдээг ирүүлэхдээ мэдээлэл зөрүүтэй, дутуу ирүүлэх, буруу ирүүлж дахин дахин засварлах байдалтай, тайлагналд хариуцлагагүй хандаж байна.

4. Нийт албаны хэмжээнд 20 нэгжид хамаарах 103 актад холбогдох тайлбар, нотлох баримтыг зохих ёсоор бэлтгэн шийдвэрийг хамгаалах шаардлагатай.

ТАВ. ХӨНДЛӨНГИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, БҮРТГЭЛ БА АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН

Хөндлөнгийн мэдээлэл цуглуулалт, бүртгэл, ашиглалтын байдлын баталгаажсан мэдээллийг Эрсдэлийн удирдлагын газрын чиг үүргийн ажил хариуцсан татварын улсын байцаагчаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр албан ёсоор гаргуулан хөндлөнгийн мэдээлэл цуглуулалт, хөндлөнгийн мэдээллийн санд бүртгэсэн ба баталгаажуулсан байдал үзүүлэлтээр өмнөх оноос өссөн байх гэсэн шалгуур нөлөөлүүлэн үнэлгээ хийхэд системийн үнэлгээ 90.04 байна.

Та код	Татварын алба	Хм цуглуулалтын үнэлгээ			Хм ашиглалтын үнэлгээ /n30/	Урд онд цуглуулж баталгаажсан хм тоо	Урд оноос буурсан нэгжүүд	Бууралт нөлөөлсөн үнэлгээ	Цуглуулалт үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ
		Цуглуулсан	Бүртгэж баталгаажсан	Хувь						
1	Архангай	228	228	100.0	100.00	157	-	100.0	100.0	100.00
2	Баян-Өлгий	32	2	6.3	100.00	30	1	6.7	6.5	53.23
3	Баянхонгор	209	206	98.6	85.96	170	-	100.0	99.3	92.62
4	Булган	175	153	87.4	100.00	423	1	36.2	61.8	80.90
5	Говь-Алтай	159	135	84.9	99.07	144	1	93.8	89.3	94.20
6	Дорноговь	113	101	89.4	100.00	88	-	100.0	94.7	97.35
7	Дорнод	243	243	100.0	99.38	163	-	100.0	100.0	99.69
8	Дундговь	138	138	100.0	100.00	183	1	75.4	87.7	93.85
9	Завхан	154	154	100.0	96.15	67	-	100.0	100.0	98.08
10	Өвөрхангай	463	463	100.0	100.00	464	1	99.8	99.9	99.95
11	Өмнөговь	55	55	100.0	100.00	127	1	43.3	71.7	85.83
12	Сүхбаатар	256	254	99.2	100.00	222	-	100.0	99.6	99.80
13	Сэлэнгэ	481	481	100.0	100.00	281	-	100.0	100.0	100.00
14	Төв	79	79	100.0	95.38	160	1	49.4	74.7	85.04
15	Увс	192	189	98.4	97.23	212	1	89.2	93.8	95.51
16	Ховд	196	192	98.0	100.00	211	1	91.0	94.5	97.24
17	Хөвсгөл	285	268	94.0	100.00	250	-	100.0	97.0	98.51
18	Хэнтий	124	124	100.0	100.00	110	-	100.0	100.0	100.00
19	Дархан-Уул	118	114	96.6	100.00	102	-	100.0	98.3	99.15
20	Орхон	560	560	100.0	99.90	555	-	100.0	100.0	99.95
21	ТТГ	1199	1199	100.0	99.15	1171	-	100.0	100.0	99.57
22	НТГ	413	413	100.0	100.00	328	-	100.0	100.0	100.00
23	Хан-Уул	801	777	97.0	100.00	865	1	89.8	93.4	96.71

24	Баянзүрх	356	348	97.8	100.00	447	1	77.9	87.8	93.90
25	Сүхбаатар дүүрэг	247	230	93.1	98.39	209	-	100.0	96.6	97.47
26	Баянгол	236	198	83.9	100.00	315	1	62.9	73.4	86.69
27	Багануур	51	50	98.0	83.71	57	1	87.7	92.9	88.30
28	Багахангай	5		-	-	0	-	-	0.0	-
29	Налайх	136	136	100.0	97.14	117	-	100.0	100.0	98.57
32	Говьсүмбэр	6		-	100.00	167	1	-	0.0	50.00
34	Сонгинохайрхан	325	325	100.0	100.00	212	-	100.0	100.0	100.00
35	Чингэлтэй	962	926	96.3	100.00	707	-	100.0	98.1	99.06
Нийт		8,889.0	8,741.0	88.1	95.40	8,714			94.0	90.04

Албаны хэмжээнд 2023 оны эхний хагас жилд нийт 8'997 хөндлөнгийн мэдээлэл цуглуулснаас 8'741 мэдээлэл буюу 88.09 хувийг баталгаажуулсан. Татварын хяналт шалгалтын чиг үүрэг олгогдоогүй гэх шалтгаанаар Багахангай дүүргийн татварын хэлтэст хөндлөнгийн мэдээлэл цуглуулалтын ажиллагаа хамгийн бага 5 ширхэг мэдээлэл цуглуулсан боловч системд баталгаажуулаагүй, ХШҮ-ний дүнгээр өмнө өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хөндлөнгийн мэдээллийн цуглуулалт, бүртгэл ашиглалтын ТҮ-4 мэдээг Архангай, Говь-Алтай, Дорнод, Өвөрхангай, Хэнтий, аймгийн татварын нэгжүүд алдаатай, буруу бэлтгэн ирүүлсэн, үнэлгээ хийх явцад тэдгээртэй холбоотой нэмэлт тодруулга залруулга шаардагдаж цаг хугацаа үрэх байдал үүссэн. Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Увс, Ховд, Говьсүмбэр аймаг, Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Багануур дүүргийн татварын хэлтэст хөндлөнгийн мэдээлэл цуглуулалт урд оны мөн үеэс буурсан.

Дүгнэлт:

1. Урд оны мөн үед 8'714 хөндлөнгийн мэдээлэл цуглуулж байсан бол тайлант оны 1-р хагас жилд энэ үзүүлэлт 8'741 болж 0.31 хувиар өссөн байна.

2. Хөндлөнгийн мэдээлэл цуглуулах ажил тухайн жилд хийгдэх татварын хяналт шалгалтын ажлын тоотой шууд хамааралтай байгаа нь уг ажил зөвхөн ТХШАЭН-ийн хийх ажил мэт ойлголт арилаагүй, бусад нэгжийн оролцоо муу байгааг харуулж байна.

3. Хяналт шалгалтаас бусад чиглэлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн мэдээлэл ашиглах байдал зогсонги, энэ чиглэлийн үйл ажиллагаагаар татварын ногдол нэмэгдүүлсэн үзүүлэлт байхгүй байна.

4. Хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжээс бусад нэгжид хөндлөнгийн мэдээлэл цуглуулах ажил хангалтгүй.

5. Багахангай дүүргийн татварын хэлтэст хөндлөнгийн мэдээлэл цуглуулах ажиллагаа хангалтгүй байгаа нь “Татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулах, санг бүрдүүлэх, ашиглах, сангийн нууцыг хамгаалах журам”-ын 4 дэх хэсгийн 4.6 дахь заалт, чиг үүргийн 3.13-т заасныг болон өмнө хийгдсэн ХШҮ-ний дүнгээр өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, орхигдуулснаас үүдсэн байна.

ЗУРГАА. ТӨРИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХЗҮЙ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН

Төрийн захиргаа, хууль эрхзүй, санхүүгийн үйл ажиллагааны түвшинг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дараах 3 дэд үзүүлэлтээр үнэлгээ хийхэд системийн дундаж 78.99 хувиар “С” буюу “Сайжруулалт хэрэгтэй” үнэлгээтэй үнэлэгдэж байна.

Үзүүлэлтүүд	Хүрэх түвшин	Гүйцэтгэл	Итгэл-цүүр	Үнэлгээ
6.5.1 Захиргаа, хүний нөөц, албан хаагчдын сургалттай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн түвшин	100.0	87.60	0.05	4.38
6.5.2 Санхүү болон үр ашигт ажиллагааны түвшин	100.0	91.11	0.04	3.64
6.5.3 Хууль, эрхзүйн үйл ажиллагааны түвшин	100.0	65.75	0.06	4.01
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ				78.99

6.1 Захиргаа, хүний нөөц, албан хаагчдын сургалттай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн түвшин:

Тус үйл ажиллагааны хэрэгжилтийн байдлыг хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийн дагуу 5 бүлэг 11 дэд үзүүлэлтээр үнэлгээ хийхэд системийн дундаж **87.60** оноогоор үнэлэгдэж байна.

Д/Д	Үзүүлэлт	Шалгуур	Хувь	Үнэлгээ	
	ТЕГ-ын даргын "А" тушаалаар өгсөн Үүрэг даалгаврын хэрэгжилтийн байдал	ТЕГ-ын даргын "А" тушаалаар харьяа нэгжид өгсөн үүрэг даалгавраас хяналтад авч, хэрэгжилтийг тайлагнах тушаалуудыг ТУНС-д бүртгэж, харьяа нэгжүүд хэрэгжилтийг тушаал бүрээр тайлагнан	20	87.41	17.48
		ДЭХ, Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	10	80.25	8.02
2	ТУНС-д хүний нөөцтэй холбоотой мэдээллийг бүртгэсэн байдал	Хүний нөөцийн программд төрийн албан хаагчийн анкетын мэдээллийг үнэн зөв, бүрэн бүртгэсэн байдал /Хувийн хэргийн бүртгэлийн хувийн дунджаар үнэлнэ/	10	95.59	9.56
		Албан хаагчдын мэдлэг чадварын байдалд судалгаа хийж, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байдал, ТЕГ-т сургалтын захиалга өгсөн байдал, өөрсдийн бололцоонд тулгуурлан сургалт явуулсан байдал	5	82.19	4.11
		Хүний нөөцийн хөдөлгөөнтэй холбоотой тушаал шийдвэрийг цаг тухай бүр программд бүрэн бүртгэсэн байдал /судалгааны үнэн зөв байдлын үзүүлэлтээр/	-	-	-
3	Өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байдал	Албан хаагчаас ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт /Хугацаанд нь шийдвэрлэсэн эсэх/	5	89.47	4.47
		1900-1288, 1800-1212, 11-11 төвд ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт	5	90.93	4.55
		ААНБ, хувь хүнээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт /албан бичгээр ирүүлсэн/	10	84.86	8.49
4	Албан хаагчдын мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн ажил, ажлын байрны сургалт зохион байгуулсан	Мэргэшүүлэх сургалтын хамрагдалт, үнэлгээний дүн	10	75.16	7.52
		Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт /ёс зүй, харилцаа, хандлага, авлигаас урьдчилан сэргийлэх/ болон Албан тушаал сэлгэх, шилжих үеийн сургалтыг тухай бүр, батлагдсан төлөвлөгөөний дагуу явуулсан байдал	10	90.00	9.00
		ТЕГ-аас зохион байгуулсан зайн болон танхимын сургалтад албан хаагчдыг хамруулж, хамтран ажилласан байдал /сургалтын чанар, үр дүнгээр, оролцооны хувиар/	10	83.72	8.37
5	ТА-ны хэмжээн д хэрэгжиж буй хөтөлбөр үүдийн биелэлт	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлагдсан тухайн оны төлөвлөгөөний гүйцэтгэл, тайлан мэдээ ирүүлсэн хугацаа, чанар үр дүнг тооцох /Сургалт хөгжлийн хөтөлбөр, Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн хувиар/	10	88.00	8.00
Нийт үнэлгээ		105	86.14	90.37	
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		87.60			

Дээрх үзүүлэлтийг харьяа албадаас ирүүлсэн тайлан, мэдээ, судалгаатай танилцаж, зарим үзүүлэлтийг ТЕГ-ын ТЗУГ-аас хийсэн үнэлгээнд тулгуурлан үнэлсэн ба хүний нөөцийн хөдөлгөөнтэй холбоотой тушаал шийдвэрийг цаг тухай бүр программд бүрэн бүртгэсэн байдал үзүүлэлтийг үнэлээгүй болно. Учир нь ТЕГ-аас гарсан хүний нөөцийн хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг программд бүртгэх хөгжүүлэлтийг ГСТМТТ-ийн УҮГ-аас түр хугацаанд хойшлуулаад байна. Татварын албаны хүний нөөц, албан хаагчдын сургалттай холбоотой үйл ажиллагаанд хийсэн ХШҮ-ний байдлыг татварын албадаар харуулбал:

Д/Д	Татварын алба	Үнэлгээ	Д/Д	Татварын алба	Үнэлгээ
1	Орхон	91.65	17	Баян-Өлгий	88.19
2	ТТТГ	91.48	18	Баянхонгор	88.13
3	Завхан	91.01	19	Архангай	88.04
4	Дархан-Уул	90.97	20	Сонгинохайрхан	87.99
5	Булган	90.69	21	Чингэлтэй	87.89
6	Багануур	90.69	22	Хөвсгөл	86.94
7	Өмнөговь	89.78	23	Говьсүмбэр	86.62
8	Увс	89.67	24	Ховд	86.60
9	Дундговь	89.62	25	Сүхбаатар	86.56
10	Дорнод	89.60	26	Сэлэнгэ	86.34
11	Налайх	89.35	27	Баянзүрх	86.00
12	Говь-Алтай	89.20	28	Сүхбаатар дүүрэг	85.87
13	Баянгол	88.76	29	Төв	82.17
14	Дорноговь	88.45	30	НТГ	80.51

15	Өвөрхангай	88.43	31	Хан-Уул	79.27
16	Хэнтий	88.23	32	Багахангай	78.57

Дээрх хүснэгтээс харахад ТТТГ, Багануур дүүрэг, Булган, Дархан-Уул, Завхан, Орхон аймгийн татварын албад 90.69-91.65 хувиар “Маш сайн”, бусад 24 татварын албад 80.51-89.78 хувиар “Сайн”, Багахангай, Хан-Уул дүүргийн татварын албад 78.57-79.27 хувиар тус тус үнэлэгдсэн байна.

Дүгнэлт:

1. ТЕГ-ын даргын “А” тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврыг татварын нэгжүүд хэрэгжүүлж гарсан үр дүнг тайлагнаж мэддэггүй, зөвхөн “мөрдөж ажиллаж байна, хяналтад авч хэрэгжүүлж байна, албан хаагчдад танилцуулсан” гэх зэргээр тайлагнаж байна. Татварын нэгжийн төрийн захиргаа, удирдлагын ажил хариуцсан нэгжийн дарга тухайн хэлтэс, газартай холбоотой тоо мэдээ, тайлангийн нэгтгэл, үнэн зөвийг хангуулах, хэрэгжүүлж буй ажлын үр дүнг шаардах ажлыг хэрэгжүүлэхгүй байна. Бодлогын нэгж нь Татварын удирдлагын нэгдсэн системд “А” тушаалын хэрэгжилтийг бүртгэхэд алдаа гарч байгаад анхаарч программын хөгжүүлэлтийг хийлгээгүй байна.

2. Хүний нөөцийн мэдээллийг ТУНС-д бүртгэж, мэдээллийг шинэчлэх ажил өмнөх оноос өссөн ч татварын албад ТАХ-ийн анкетын үндсэн мэдээллийн туршлага хэсэгт хэлтэс, алба албан тушаал, орсон гарсан тушаалын огноо дугаарыг дутуу болон зөрүүтэй бүртгэх байдал засрахгүй байна. Энэхүү мэдээлэл дутуугаас шалтгаалан ажилласан жилийн тооцоолол гарахгүй, тухайн албан хаагчийн түүхийг харах боломжгүй байгаад татварын албад дүгнэлт хийх шаардлагатай байна.

3. Нийт татварын албадын 25 хувь буюу 8 татварын алба нь албан хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй, өөрсдийн нөөц бололцоонд хийсэн сургалт нь тогтмол жил бүр хийгддэг сургалт байдаг тул албан хаагчдын хэрэгцээ шаардлагыг хангадаггүй байна.

4. Татварын албад төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан ч албан хаагчийг албан тушаал, сэлгэх, шилжих, шинээр албан хаагч томилогдсон үед дагалдуулан сургах ажил хангалттай хийгдэхгүй байна.

5. “Монголын Татварын албаны ажилтан, албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөр” “Татварын албаны ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд тухайн жилд хэрэгжүүлэх ажлыг газар хэлтсийн даргаар батлуулсан ч зарим татварын албад шинэчлэн батлагдсан хөтөлбөрийн хүрээнд батлаагүй, нийгмийн баталгаа хангах болон сургалт хөгжлийн хөтөлбөрийг хооронд нь хольсон, тайлагнах байдал нь ихэнх татварын албадад ялангуяа сургалт хөгжлийн хөтөлбөр хангалтгүй байна. Хэрэгжилтийг тайлагнахдаа сургалт зохион байгуулсан гэх зэргээр хэрэгжүүлсэн ажлаа ерөнхий байдлаар тайлагнаж, хүрсэн үр дүнг тоо мэдээтэй тайлагнахгүй байна.

6.2 Санхүү болон үр ашигт ажиллагааны түвшин

Санхүүгийн болон үр ашигт үйл ажиллагааны түвшин шалгуур үзүүлэлтийг журамд тусгасны дагуу 5 дэд үзүүлэлтээр үнэлгээг хийхэд системийн хэмжээнд **91.11** оноогоор “А” үнэлэгдлээ.

Санхүүгийн болон үр ашигт үйл ажиллагааны түвшин шалгуур үзүүлэлтийн 1, 2-р дугаар үзүүлэлт буюу авлага өглөгийн байдал үзүүлэлтийг татварын нэгжийн СХОХ-г нэгтгүүлсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг хугацаанд нь үнэн зөв тайлагналтыг үндэслэн, 3-р үзүүлэлтийн Аудитын байгууллагаас өгсөн акт, зөвлөмж албан шаардлагын хэрэгжилт зөрчил, дутагдалгүй ажилласан байдал, 4-р үзүүлэлтийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангасан байдлыг <https://www.shilendans.gov.mn/> цахим хуудсанд мэдээлсэн хувь болон улирлын тайланг илгээсэн байдлаар, 5 дугаар үзүүлэлт Худалдан авах төлөвлөгөөгөө батлуулах, хөрөнгө, бараа материал зарцуулалт хяналтын байдал, Хагас жилийн тооллого өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлт гэсэн үзүүлэлтүүдийг харгалзан үнэлсэн болно.

Д / Д	Үзүүлэлт			Шалгуур	Хэрэгжилтийн суурь хувь	Тоо, хувь	Үнэлгээ
1	Санхүүгийн байдал	Бусад өгөх өрийн дүн	Тайланг хугацааны	эхэнд	442,000.0	12,750.0	84.38
				эцэст	12,750.0	20,637,199.8	
		Авлагын дүн	Тайланг хугацааны	эхэнд	19,720,600.0	16,694,077.3	95.94
				эцэст	16,803,807.3	15,863,434.0	
2		Төсөвт зардлын дүн	батлагдсан	36,507,331,700.0	21,020,349,000.0		

			гүйцэтгэл	33,328,744,259.8	20,274,908,957.1	
			хувь	91.34	96.15	
	Төсвийн хуулийн хэрэгжилт		Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, зардлыг бүлэг хооронд шилжүүлэн тодотгож, зардлын зүйлийн хувьд хэтрэлт гараагүй байна	97.06	99.22	92.86
			Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээ хугацаанд нь ирүүлсэн, Санхүүгийн нэгжээс ирүүлсэн удирдлага арга зүйг хэрэгжүүлсэн байдал	86.67	86.50	
			Хязгаарлалттай санал дүгнэлт	83.75	79.06	
3	Аудит ХШ-ын байгууллагын шалгалтаар зөрчил дутагдалгүй ажилласан байдал	Аудит, хяналт шалгалтын байгууллагын дүгнэлт	Төлбөрийн акт	43.33	63.33	83.28
4	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангасан байдал			94.56	92.50	97.75
5	Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, хяналт тавих	ТБОНХАҮХАТХууль болон холбогдох журмын хэрэгжилт		0.00	94.59	
			Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилт	83.75	90.31	92.45
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ						91.11

Санхүүгийн байдал:

2023 оны эхний хагас жил 23 татварын алба авлага, өглөгийн эхний үлдэгдэлгүй, авлага өглөгийг шинээр нэмж үүсгэлгүй үзүүлэлтийг хангалттай биелүүлж 100.0 оноогоор дүгнэгдлээ.

Өглөгийн талаар:

2023 оны эхний хагас жил Өмнөговь өглөгийн үлдэгдлээ барагдуулж Дорнод, Төв аймаг, ТТТГ, Хан-Уул, Багануур дүүргүүд 20,637.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй болж Тайлант хугацаанд өмнөх оноос өглөг 20,637.2 мянган төгрөгөөр нэмэгдэж албадын дунджаар **84.38** гүйцэтгэлийн хувь байна.

Авлагын талаар:

2022 онд 6 татварын алба 16,694.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байсан бол 2023 оны эхний хагас жил 4 татварын алба 15,863.4 мянган төгрөгийн авлагатай болж авлага 830.6 мянган төгрөгөөр буурч албадын дунджаар **95.94** гүйцэтгэлийн хувь байна.

Төсвийн хуулийн хэрэгжилт

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, зардлыг бүлэг хооронд шилжүүлэн тодотгож, зардлын зүйлийн хувьд хэтрэлт гараагүй байдлыг албадын дунджаар **99.22** хувиар, Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг СХОХ-ээс татварын албадын мэдээг хүлээн авч нэгтгэдэг тул журмын дагуу мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлсэн байдлаар албадын дунджаар **86.50** хувиар дүгнэн ДАХШҮГ-т ирүүлсэнд харгалзан үнэлгээ хийсэн.

Аудит, хяналт шалгалтын байгууллагын дүгнэлт

2022 онд Аудит, хяналт шалгалтын байгууллага, ТЕГ-ын ДАХШҮГ-аас хийсэн шалгалтаар зөрчил дутагдалгүй ажилласан байдлыг албадын дунджаар 83.28 хувиар үнэлсэн болно.

Өвөрхангай хэрэгжилтийг бүрэн хангаж 100 оноогоор, Баян-Өлгий, Говь-Алтай, Багахангай албад төлбөрийн акт 11 албад албан шаардлага, 27 албад зөвлөмж зэрэг алдаа зөрчил гаргасан тул үнэлгээг тус тус бууруулсан болно.

№	Татварын албад	Төлбөрийн актын тоо	Албан шаардлагын тоо	Зөвлөмжийн тоо	Үнэлгээний хувь
1	Татварын 32 алба	9	24	64	83.28

Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал

Шилэн дансны хуулийн хэрэгжилт, гүйцэтгэлийг www.shilendans.gov.mn сайтад байршуулбал зохих нийт 3-н бүлгийн 76 мэдээллийг хуулийн хугацаанд нь байрлуулсан эсэх мөн улирлын бүрийн шилэн дансны мэдээлэл илгээсэн байдалд тулган шалгаж **92.50** хувиар үнэллээ.

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, хяналтын байдал

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, төрийн өмчийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж буй байдлыг үнэлэхдээ 2023 онд Бараа материалын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө баталсан эсэх, Нягтлан бодох бүртгэлийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан эд хөрөнгийн тооллого хийх комисс байгуулж, тооллого хийсэн эсэх, тооллогын илтгэх хуудас, үндсэн хөрөнгийн тайлан, материалын хөдлөлийн тайлан, эд хөрөнгийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнүүлсэн эсэхийг **97.75** хувиар үнэлсэн.

Үнэлгээ: 91.11 хувь

Дүгнэлт:

1. Олон жил дамнаж удааширсан авлагыг СХОХ-ээс холбогдох хууль хяналтын байгууллагаар эцэслэн шийдвэрлүүлээгүй байна. Үүнд: 1996 онд НТГазар 9,832.4 мянган төгрөг, Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс 726.2 мянган төгрөг, Хөвсгөл аймгийн татварын хэлтэс 1,397.0 мянган төгрөгийн 11,955.6 мянган төгрөгийн Сэргээн босголт банк татан буугдах үед байршиж байсан харилцах дансны үлдэгдэл найдваргүй авлагыг холбогдох хууль хяналтын байгууллагад өгч шийдвэрлүүлээгүй байна.

2. Баянзүрх дүүргийн татварын хэлтэс өмнөх орнуудад үүссэн ажлаас гарсан ОТББ-аас авах 2,178.4 мянган төгрөгийн авлагаа холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан боловч иргэний журмаар барагдуулаагүй байна.

3. Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын НХМаягт БМ-7 маягтыг хөтөлж тооцоо нийлж гарын үсэг зурж баталгаажуулалт ирүүлэхгүй байна.

6.3 Хууль, эрх зүйн үйл ажиллагааны түвшин

Татварын албаны хууль эрх зүйн үйл ажиллагааны түвшинг үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийн дагуу 3 бүлэг үзүүлэлтийн 14 дэд үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд татварын албадын дундаж **65.75** хувиар **“D”** буюу **“Хангалтгүй”** үнэлгээтэй үнэлэгдэж байна.

Д/д	Үзүүлэлт	Үнэлгээ
1	Хууль хяналтын байгууллагатай хамтран ажилласан байдал	88.32
2	Зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй хамтран ажилласан байдал	42.90
3	Татварын маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааны байдал	88.78
Албадын дундаж		65.75

Хууль эрх зүйн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээг алба бүрээр нэгтгэн харуулбал:

Д/д	Татварын алба	Үнэлгээ
1	Чингэлтэй дүүрэг	99.00
2	Орхон	98.30
3	Сүхбаатар дүүрэг	97.74
4	ТТТГ	95.94
5	Баянзүрх	95.26
6	Өвөрхангай	92.19
7	Архангай	91.67
8	Баян-Өлгий	90.52
9	Сонгинохайрхан	90.46
10	Дархан-Уул	89.46
11	Хөвсгөл	82.21
12	Багануур	81.54
13	Булган	80.00
14	НТГ	76.61
15	Өмнөговь	72.33
16	Говь-Алтай	68.88

Д/д	Татварын алба	Үнэлгээ
17	Сэлэнгэ	62.50
18	Баянгол	55.00
19	Увс	45.95
20	Сүхбаатар	45.83
21	Хэнтий	45.71
22	Баянхонгор	45.00
23	Хан-Уул	44.02
24	Дорнод	42.92
25	Ховд	40.83
26	Налайх дүүрэг	40.63
27	Дорноговь	38.10
28	Говьсүмбэр	36.25
29	Дундговь	34.05
30	Завхан	29.81
31	Төв	29.44
Нийт		65.75

Татварын албаны хууль эрх зүйн үйл ажиллагааны үзүүлэлтээс харахад 9 татварын алба 90.46-99.00 хувиар “Маш сайн”, 4 татварын алба 80.00-89.46 хувиар “Сайн”, 2 татварын алба 72.33-76.61 хувиар “Хангалттай”, 2 татварын алба 62.50-68.88 хувиар “Хангалтгүй”, 14 татварын алба 29.44-45.95 хувиар “Маш муу” гэж тус тус үнэлэгдлээ. Хууль эрх зүйн үйл ажиллагааг үзүүлэлт бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах байдалтай байна.

Хууль хяналтын байгууллагатай хамтран ажилласан байдал:

Хууль хяналтын байгууллагатай хамтран ажилласан байдлыг 5 дэд үзүүлэлтээр ХШҮ хийхэд 88.32 хувиар үнэлэгдлээ. Үүнд:

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр татварын албаны талд шийдвэрлэгдсэн байдал;

Тайлант хугацаанд албаны хэмжээнд Иргэний хэргийн шүүхээр 11 татварын албанд хамаарах 19 татвар төлөгчтэй холбоотой 1.5 тэрбум төгрөгийн хэрэг маргаан татварын албаны талд бүрэн шийдвэрлэгдсэн байна. Шүүхийн шийдвэрээс харахад татвар төлөгчийг эрэн сурвалжлах, төлбөрийн чадваргүй болгосныг тогтоолгож дампуурсанд тооцох, өв залгамжлагчгүй, өвлүүлэх хөрөнгөгүй болохыг тогтоох, авлага хүчингүй болгох зэрэг хэрэг маргаанууд байна. Бусад 20 татварын албанд иргэний хэргийн шүүхээр татварын хэрэг маргаан шийдвэрлэгдээгүй байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр татварын албаны талд шийдвэрлэгдсэн байдал;

Тус үзүүлэлтийг 2 дэд үзүүлэлтийн дунджаар тооцсон ба тайлант хугацаанд албаны хэмжээнд захиргааны хэргийн шүүхээр 19 татварын албад хамаарах 74 татвар төлөгчтэй холбоотой 146.1 тэрбум төгрөгийн хэрэг маргаан шийдвэрлэгдсэн ба татварын албад шүүхэд хариуцагч, хариу тайлбар гаргах, нотлох баримтыг хүргүүлэх ажлыг хэрэгжүүлж тогтоосон шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна. Дээрх татвар төлөгчдийн хэрэг маргаанаас 78.25 хувь буюу 114.2 тэрбум төгрөгийн хэрэг маргааныг татварын албаны талд шийдвэрлүүлж, тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна.

Тус үзүүлэлтээр Булган, Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий аймаг, НТГ, Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангасан бол Говь-Алтай, Завхан, Орхон аймаг, ТТТГ, Сүхбаатар, Баянзүрх, дүүрэг 0.00-99.94 хувиар тус тус үнэлэгдэж байна. Бусад 12 татварын албанд захиргааны хэргийн шүүхээр татварын хэрэг маргаан шийдвэрлэгдээгүй байна.

Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн байдал:

Тайлант хугацаанд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг хэрэг нээсэн, хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн хэрэг маргааныг, аймаг, нийслэл, дүүргийн прокурорын байгууллагад хянуулах, дуусгах үйл ажиллагаанд хууль эрх зүйн зөвлөгөөгөөр хангах, прокурорын байгууллагад татварын албыг төлөөлөн ажиллах үйл ажиллагаа системийн хэмжээнд 69.68 оноогоор үнэлэгдэж байна.

Тайлант хугацаанд нийт 973 татвар төлөгчдөд зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, харьяалагдах прокурорын байгууллагад хянуулсан байна. Хэдийгээр татварын албад Зөрчил тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага тооцсон ч Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд, Хэнтий, Дархан-Уул аймаг, Налайх, Багануур дүүргийн татварын хэлтсийн ЗХТ-нь үндсэн чиг үүргийн хүрээнд хяналт тавих үүргийг бүрэн биелүүлээгүй тул үнэлгээг бууруулан үнэлсэн. Учир нь тайланд хугацаанд иргэдээс НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй буюу төлбөрийн баримт олгоогүй гэх 748 гомдол, сар улирлын татварын тайлан /НӨАТ/хоцроосон 15'709 ААН, нийт 16'457 зөрчил бүртгэгдсэнээс 973 татвар төлөгчдөд буюу 5.9 хувьд нь хариуцлага тооцсон байна.

Татварын байгууллагын удирдлагын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд батлан гаргасан тушаал, шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэлийг хянах, хянуулах, гарсан зөрчлийг арилгасан байдал;

Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хүрэх түвшний шалгуур үзүүлэлтэд тухайн татварын албанаас гаргасан захиргааны тушаал, шийдвэрийг ТЕГ-ын ХХХГ-аар хянуулсан байхаар баталсан. ТЕГ-ын ХХХГ-аас ирүүлсэн дүнгээр тус үзүүлэлт 91.73 оноогоор үнэлэгдэж байна.

Тайлант хугацаанд ТЕГ-ын ХХХГ нь татварын албадын даргын батлан гаргасан 1'402 ширхэг А, Б тушаалыг хянасан ба тус газраас ирүүлсэн тоонд үндэслэн үнэлэхэд 116 тушаал хуулийн зүйл заалтыг дутуу, буруу хэрэглэсэн дутагдал байна. Архангай, Баянхонгор, Сүхбаатар, Орхон аймаг, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг тогтоосон шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан бол Өвөрхангай, Баян-Өлгий аймаг 63.16-64.71 хувь, Дорноговь аймаг 78.57 хувь, бусад татварын албадад 80.00-98.04 хувь тус тус үнэлэгдлээ.

Хяналт шалгалтын байцаагч нартай хамтран ажилласан байдал;

Тайлант хугацаанд 12 татварын албанд хамаарах татварын улсын байцаагчийн бичсэн 134 танилцуулга хууль хяналтын байгууллагад хянагдаж байгаагаас 104 дүгнэлтийн шийдвэрлэлтийг хангах талаар холбогдох газарт албан бичиг явуулж, хариуг хүлээн авсан ба 77.61 хувиар үнэлэгдэж байна. Баян-Өлгий, Өвөрхангай, Төв аймаг, ТТТГ, Налайх, Чингэлтэй дүүрэг тогтоосон шалгуур

үзүүлэлтийг хангасан бол Хан-Уул 57.14, Баянзүрх 66.67, Баянгол 60.00, Сонгинохайрхан дүүрэг 38.46, НТГ-75.00 оноогоор тус тус үнэлэгдлээ. Бусад 19 татвар албадад хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн танилцуулга гараагүй байна.

Зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй хамтран ажилласан байдал:

Татварын өр хураах үйл ажиллагаанд бусад нэгжүүдтэй хамтран өртэй татвар төлөгчийн хөрөнгө байдлыг тогтоох, хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, эд хөрөнгийн үнэлгээ хийлгэх, битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх зэрэг ажлыг зохион байгуулсан, хууль эрх зүйн туслалцаа үзүүлсэн үзүүлэлтээр албаны дунджаар 42.90 хувиар үнэлэгдсэн. Тус үйл ажиллагааг 16 татварын албад хэрэгжүүлж, үлдсэн 15 татварын алба хэрэгжүүлээгүй байна.

Тайлант хугацаанд албаны хэмжээнд нийт 24 татвар төлөгчийн 22.2 тэрбум төгрөгийн татварын өрөнд эд хөрөнгө, авлагыг битүүмжилсэн ба Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Дархан-Уул, Орхон аймаг, ТТТГ, Баянзүрх, Багануур, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг тус шалгуур үзүүлэлтийг хангасан бол бусад 5 татварын алба өртэй татвар төлөгчийн хөрөнгө, авлага битүүмжлэх ажиллагааг хэрэгжүүлээгүй, өмнөх онд битүүмжилсэн хөрөнгө, авлагыг мөнгөн хэлбэрт шилжүүлэх, дуудлага худалдаа зохион байгуулах зэрэг ажлыг хэрэгжүүлсэн тул журмын дагуу 50.00 хувиар тус тус үнэлсэн.

Татварын маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааны байдал:

Батлагдсан журамд заасны дагуу татварын маргаан таслах зөвлөлд гаргасан татвар төлөгчийн урьд оны гомдлыг бүрэн шийдвэрлэсэн байдал, тайлант хугацаанд маргаан таслах зөвлөлд гаргасан татвар төлөгчийн урьд оны гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байдал, маргаан таслах зөвлөлийн тогтоолыг татвар төлөгчдөд хугацаанд нь гардуулсан байдал зэрэг үзүүлэлтээр ХШҮ хийхэд 88.78 хувиар үнэлэгдсэн.

Аймаг нийслэлийн татварын газар, хэлтсийн дэргэдэх 7 татварын маргаан таслах зөвлөлд өмнөх оны үлдэгдэл гомдол 9, тайлант хугацаанд 30 татвар төлөгч татварын акттай холбоотой гомдол гаргасан байна. Шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Үзүүлэлт		Хэрэгжилт	
1	Урьд онд ТБМНС-д бүртгэсэн гомдол, маргааны шийдвэрлэлтийн байдал	Бүртгэгдсэн	Актны тоо	9
			Төлбөрийн дүн	2,884,528,438.0
		Шийдвэрлэсэн	Актны тоо	8
			Төлбөрийн дүн	1,432,962,385.0
2	Тайлант хугацаанд ТБМНС-д бүртгэсэн гомдол, маргааныг шийдвэрлэлтийн байдал	Бүртгэлтэй	Актны тоо	30
			Төлбөрийн дүн	17,426,805,859.0
		Хугацаа хойшлуулах хүсэлт өгсөн, үүссэн гомдлоо буцаасан	Актны тоо	2
			Төлбөрийн дүн	887,727,626.0
		Шийдвэрлэвэл зохих	Актны тоо	28
			Төлбөрийн дүн	16,539,078,233.0
		Шийдвэрлэсэн	Актны тоо	26
			Төлбөрийн дүн	6,132,672,651.0
3	Татвар төлөгчийн ирүүлсэн гомдол маргааныг хугацаанд нь шийдвэрлэсэн байдал	Шийдвэрлэвэл зохих	Актны тоо	37
			Төлбөрийн дүн	19,423,606,671.0
		Хугацаанд нь шийдвэрлэвэл зохих	Актны тоо	37
			Төлбөрийн дүн	19,423,606,671.0
		Шийдвэрлэсэн байдал	Актны тоо	23
			Төлбөрийн дүн	11,103,407,152.0
		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн болон хугацаанд нь шийдвэрлэгдээгүй байдал	Актны тоо	14
			Төлбөрийн дүн	8,317,173,972.0

2022 оны жилийн эцсийн байдлаар урьд оны үлдэгдэлтэй 9 татвар төлөгчийн 2.8 тэрбум төгрөг, тайлант онд 30 татвар төлөгчийн 17.4 тэрбум төгрөгийн гомдол, нийт 39 татвар төлөгчийн 20.3 тэрбум төгрөгийн гомдол маргаан бүртгэгдсэнээс 2 татвар төлөгчийн 887.7 сая төгрөгийн гомдлыг хүлээн авахаас татгалзсан, буцаасан ба тайлант хугацаанд 34 татвар төлөгчийн 14.7 тэрбум төгрөгийн гомдол маргааныг шийдвэрлэсэн байна. Татварын газар, хэлтсийн дэргэдэх маргаан таслах зөвлөлөөс урьд оны болон тайлант онд татвар төлөгчөөс ирүүлсэн 37 гомдол маргаанаас 23 гомдол маргааныг хугацаанд нь шийдвэрлэж 14 гомдол маргааныг хугацаанд нь шийдвэрлээгүй байна.

Мөн маргаан таслах зөвлөлийн тогтоол шийдвэрийг ЗГ-ын 2019 оны 466 дугаар тогтоолоор баталсан “Маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.6-д заасан хугацаанд

гардуулсан эсэхэд ХШҮ хийхэд 34 татвар төлөгчтэй холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэсэн тогтоолыг хугацаанд нь татвар төлөгчдөд гардуулсан байна. Тус үзүүлэлтээр Баян-Өлгий, Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон аймаг 100.0 хувь, Төв аймаг 0.0 хувь, НТГ 89.52 хувиар тус тус үнэлэгдэж байна. Бусад аймгийн татварын хэлтсийн дэргэдэх маргаан таслах зөвлөлд татварын улсын байцаагчийн тавьсан акттай холбоотой гомдол гараагүй байна.

Дүгнэлт:

1. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг 12 татварын алба 1-11 татвар төлөгчдөд хэрэгжүүлсэн нь маш хангалтгүй бол бусад татварын албад 15-120 төлөгчдөд зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлсэн байна.

ТЕГ-ын даргын 2020 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан “Татварын ерөнхий газрын харьяа нэгжийн бүтэц, чиг үүргийг батлах тухай”-д Захиргаа, хуулийн тасгийн чиг үүрэгт “Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасны дагуу Захиргаа хуулийн нэгжийн дарга чиг үүргийн ажлын гүйцэтгэлийн чанарт хяналтыг бүрэн тавиагүй байна.

2. Татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, өртэй татвар төлөгчийн хөрөнгө байдлыг тогтоох, хөрөнгө битүүмжлэх үйл ажиллагааг 15 татварын албад буюу 48.38 хувь нь хэрэгжүүлээгүй нь нэгж хоорондын ажлын уялдаа болон хамтран ажиллах ажиллагаа хангалтгүйгээс шалтгаалсан байна. Мөн ХХХГ-аас “Татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г НТГ, дүүргийн татварын албанд харьяалагдах өртэй татвар төлөгчийн нэрсийг хүргүүлсэн ч НТГ, Хан-Уул, Налайх, Баянгол дүүрэг тус тус хэрэгжүүлээгүй байна.

3. Татварын албадын даргын гаргасан тушаал шийдвэрийн 1-12 тушаалын хууль эрх зүйн үндэслэл нь дутуу, хамааралгүй хуулийн зүйл заалтыг хэрэглэсэн зэрэг зөрчил гаргасан нь тухайн тушаалын төслийг хуулийн мэргэжилтэн бүрэн хянаагүйтэй холбоотой байна. Ялангуяа Баян-Өлгий /12/, Өвөрхангай/7/, Дорноговь/9/ аймгийн татварын хэлтсийн даргын баталсан 7-12 тушаал нь зөрчилтэй байна.

4. НТГ-ын дэргэдэх маргаан таслах зөвлөл нь татвар төлөгчийн ирүүлсэн гомдол маргааныг шийдвэрлэх ажил хэдийгээр 90.91 хувьтай байгаа ч хугацаанд нь шийдвэрлээгүйгээс /хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн/ шалтгаалан үнэлгээг буурч байгааг анхаарах шаардлагатай байна.

ДОЛОО. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТҮВШИН

Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийн байдал /ТУ-6/ маягт нь татвар төлөгчийн ЦТБС-д холбогдсон, баримт илгээсэн, хууль хэрэгжүүлээгүй татвар төлөгчид хариуцлага тооцсон, төлбөрийн баримтын талаар ирүүлсэн гомдлын шийдвэрлэлт гэсэн 4 үзүүлэлтийн гүйцэтгэлийн дундаж хувийг гаргасан. Маягтын тоон мэдээллийг статистик, судалгаа мэдээллийн нэгдсэн систем /таблиц/- болон ГСМТТ УҮГ-с ирүүлсэн судалгаа, мэдээллийг үндэслэсэн болно.

Үзүүлэлтүүд	2023 хагас жил
	Гүйцэтгэлийн хувь
Татвар төлөгчийг НӨАТ-ын нэгдсэн системд холбосон байдал	100.00
Нэгдсэн системд холбогдсон татвар төлөгчийн төлбөрийн баримт олгож буй байдал, давтамж	42.98
НӨАТ-ын хууль хэрэгжүүлээгүй татвар төлөгчид хариуцлага тооцсон байдал	76.87
Төлбөрийн баримт олгоогүй гомдлын шийдвэрлэлтийн байдал	91.26
ГҮЙЦЭТГЭЛИЙН ДУНДАЖ ХУВЬ	77.91

7.1 Татвар төлөгчийг НӨАТ-ын нэгдсэн системд холбосон байдал

ЦТБС, ТУНС-д бүртгэлтэй татвар төлөгчийн мэдээллээс бодит цагийн горимоор мэдээлэл татагддаг хөгжүүлэлт хийсэн тул 100 хувиар үнэлэв. Хөгжүүлэлт хийгдсэнээр татварын төлөгчийг ЦТБС-д холбоход автоматаар холбогдох боломж бүрдсэн.

7.2 Нэгдсэн системд холбогдсон татвар төлөгч төлбөрийн баримт олгож буй байдал, давтамж

ГСМТТ УҮГ-с ирүүлсэн судалгаа мэдээлэлд үндэслэн татвар төлөгчийн цахим төлбөрийн баримтын системд мэдээлэл илгээсэн байдлыг гаргасан.

Он	ЦТБС-д холбогдсон татвар төлөгчийн тоо	Баримт олгосон татвар төлөгчийн тоо	Гүйцэтгэлийн хувь
2023 хагас жил	503'977	208'839	42.98

Дээрх хүснэгтээс харахад бүртгэлтэй 503'977 татвар төлөгчөөс төлбөрийн баримт илгээсэн 208'839 татвар төлөгч байна. Нийт бүртгэлтэй татвар төлөгчөөс:

Хуулийн этгээдийн хувьд: **"Салбар"** гэсэн төрлөөс бусад хариуцлагын хэлбэрээр бүртгэгдсэн ТТ-с 2023 оны эхний хагас жилийн тайлангаар "Х" тайлан ирүүлсэн ТТ-г хасч ЦТБС-д бүртгэгдвэл зохих татвар төлөгчийг гаргасан.

Иргэний хувьд: Тайлант онд татварын төрлийн бүртгэл Хувь хүний орлогын албан татварын төрлөөр бүртгэлтэй, ТТ-06 маягтын 4-р буюу Үйл ажиллагааны орлоготой тайлагнасан, ТТ-12 маягтаар суутгуулаагүй орлого авсан, Алт тушаасан, ЦТБС-р төлбөрийн баримт олгосон, QR-р ЦТБС-д холбогдсон зэрэг үзүүлэлтийг шалгуурыг ажиллуулж ЦТБС-д холбогдвол зохих татвар төлөгчийг гаргасан бол төлбөрийн баримт илгээсэн мэдээллийг ГСМТТ УҮГ-с 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд ЦТБС-д бүртгэгдсэн татвар төлөгчийн мэдээллээр гаргасан.

7.3 НӨАТ-ын хууль хэрэгжүүлээгүй татвар төлөгчид хариуцлага тооцсон байдал

ТУ-6 маягтын 3-р үзүүлэлтийн хууль хэрэгжүүлээгүй татвар төлөгчид хариуцлага тооцвол зохих татвар төлөгчийг ТЕГ-ын ХХХГ-НӨАТХ-с тодорхойлсон тайлан хугацаанд удаа дараа гомдол ирсэн татвар төлөгчөөс хариуцлага тооцсон байдлаар тодорхойлсон болно.

Он	Төлбөрийн баримт олгоогүй талаар ирсэн нийт гомдлын тоо	Хариуцлага тооцсон татвар төлөгчийн тоо	Гүйцэтгэлийн хувь
2023 хагас жил	748	575	76.87

ТЕГ-ын холбогдох ЗББН-с удирдамж төлөвлөгөө боловсруулан, чиглэл арга зүйгээр хангаж ажилласан хэдий ч хууль хэрэгжүүлээгүй, удаа дараа гомдол ирсэн татвар төлөгчийг тодорхойлоогүй, хариуцлага тооцсон байдал хангалтгүй, хариуцлага тооцох боломжгүй ч гомдол ирүүлээд байгаа татвар төлөгчийг тодорхойлж холбогдох арга хэмжээ аваагүй, уялдаагүй ажилласан байна.

7.4 Төлбөрийн баримт олгоогүй гомдлын шийдвэрлэлтийн байдал

ТУ-6 маягтын 4-р үзүүлэлт төлбөрийн баримт олгоогүй гомдлын шийдвэрлэлтийн байдлыг дүгнэхдээ Дуудлагын төвөөс ирүүлсэн судалгаа, мэдээлэлд үндэслэсэн болно.

Тайлант хугацаанд ЦТБС-ийн холбоотой нийт 16124 гомдол ирсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 257 гомдлоор өссөн, тайлант хугацаанд 14715 гомдлыг барагдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 90 гомдлоор буурсан бол гүйцэтгэлийн хувь 91.26 буюу өмнөх оны мөн үеийнхээс 2.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Татварын алба	Ирсэн	Шийдвэрлэсэн	Хувь
Архангай	219	215	98.17
Багануур	147	145	98.64
Багахангай	8	5	62.50
Баян-Өлгий	151	142	94.04
Баянгол	1880	1685	89.63
Баянзүрх	2449	2288	93.43
Баянхонгор	171	162	94.74
Булган	117	111	94.87
Говь-Алтай	90	75	83.33
Говьсүмбэр	68	65	95.59
Дархан-Уул	637	563	88.38
Дорноговь	486	449	92.39
Дорнод	330	308	93.33
Дундговь	124	124	100.00
Завхан	195	181	92.82
Налайх	122	121	99.18
НТГ	6	4	66.67
Орхон	1114	1017	91.29
Өвөрхангай	224	196	87.50

Өмнөговь	392	354	90.31
Сонгинохайрхан	837	769	91.88
Сүхбаатар	52	38	73.08
Сүхбаатар дүүрэг	1663	1414	85.03
Сэлэнгэ	260	199	76.54
ТТГГ	10	10	100.00
Төв	110	98	89.09
Увс	131	120	91.60
Хан-Уул	2290	2188	95.55
Ховд	246	193	78.46
Хөвсгөл	324	282	87.04
Хэнтий	177	170	96.05
Чингэлтэй	1094	1024	93.60
НИЙТ	16124	14715	91.26

Дүгнэлт:

1. ТЕГ-ын холбогдох ЗББН-ээс хүргүүлсэн удирдамж, төлөвлөгөөг хангалтгүй хэрэгжүүлж байна.
2. ЦТБ-тай холбоотой гомдолд хамаарах татвар төлөгчийг тодорхойлоогүй байна.
3. Хууль хэрэгжүүлээгүй татвар төлөгчид хүлээлгэсэн хариуцлагыг ТУНС-д бүртгэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хангаагүй байна.
4. Хууль хэрэгжүүлээгүй, удаа дараа гомдол ирсэн татвар төлөгчийн бүртгэл хөтөлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг шат дараалалтай хэрэгжүүлээгүй.

НАЙМ. ЭРДЭС БАЯЛАГ, ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН

ТТГГ-ын Эрдэс баялгийн татварын хэлтсийн үйл ажиллагаанд батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийхэд **88.92** хувиар **“В”** буюу **“Сайн”** үнэлгээтэй үнэлэгдэж байна. Үнэлгээг танилцуулбал:

Д/Д	Үзүүлэлт	Үнэлгээ
1	Төрөөс эрдэс баялаг, уул уурхайн салбарт баримталж буй татварын бодлого, татварын болон ашигт малтмалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрдэс баялагийн чиглэлээр байгуулсан гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын нэгжүүдтэй хамтран мэргэжил, арга зүйн баримт бичгийг боловсруулах	100.0
2	Эрдэс баялаг, газрын тос, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн ашигт малтмалын бүтээгдэхүүний олборлолт, үйлдвэрлэл, экспорт, дэлхийн зах зээлийн үнийн төлөв хандлага, санхүүгийн байдал, татвар ногдуулалт, төлөлтөд судалгаа, шинжилгээ хийх	85.0 90.0 95.0
3	Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах	85.0
4	Эрдэс баялаг, газрын тос, уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн байгуулсан ХОГ, ТБГ, Бүтээгдэхүүн хуваах болон олон улсын гэрээний хэрэгжилтэд татварын орчны судалгаа, дүгнэлт хийх, санал төсөл боловсруулах	90.0
5	Эрдэс баялаг, газрын тос, уул уурхайн салбарын татвар төлөгчдийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, орд, уурхай, геологи хайгуулын ажлын мэдээллийг төрийн холбогдох байгууллагаас авч, мэдээллийн сан бүрдүүлэх, шинэчлэх, мэдээллээр хангах	90.0
6	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, эрх шилжүүлсэн, борлуулсны орлогын албан татварын ногдуулалтын байдалд хяналт тавих, татварын тодорхойлолт олгох, хөндлөнгийн мэдээллийн санд бүртгүүлэх	90.0
7	Эрдэс баялаг, газрын тос, уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгчдийн татварын болон ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн холбогдох заалтын хэрэгжилтийг татварын албаны хэмжээнд хангуулах, хяналт тавих	70.0
8	“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайлан”-г батлагдсан маягтын дагуу гаргаж хүргүүлэх	90.0
9	Татварын хяналт шалгалтын ажлын хүрээнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, техникийн туслалцаа үзүүлэх, хяналт шалгалтад хамтран оролцох,	90.0
10	Татварын албадаас эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн талаар мэдээ судалгааг гаргуулах ажлыг зохион байгуулах, албадыг холбогдох мэдээллээр хангах, хяналт тавих	70.0
11	Эрдэс баялаг, газрын тос, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн татварын хяналт шалгалт, ногдуулалт, төлөлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд зааварчилгаа, чиглэл өгөх, хамтран ажиллах	100.0

12	Эрдэс баялаг, ашигт малтмалын бүтээгдэхүүний олборлолт, үйлдвэрлэл, экспорт, татварын орлого, дэлхийн зах зээлийн үнийн мэдээллийн эмхэтгэл гаргах, үнэ ханшийн мэдээллийг мөрдөж буй тогтоол, журмын дагуу бэлтгэн гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, татварын ногдуулалт, төлөлтөд ашиглах	100.0
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		88.92

Дүгнэлт:

1. Татварын болон ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн холбогдох заалтын хэрэгжилтэд судалгаа хийж, мэдээллийг татварын албад хүргүүлсэн ч илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан талаар тоо мэдээ, гарсан үр дүнг нотлох баримтаар ирүүлээгүй тул үнэлгээ буурж дүгнэгдсэн.

2. Татварын албадаас эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн талаар мэдээ судалгааг гаргуулах ажлыг зохион байгуулсан ч үр дүнг тооцоогүй, хяналт тавиагүй байна. /тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгчийг бүртгэсэн эсэх, тайлагнасан эсэх, татварт хамрагдсан эсэх/

ЕС. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТҮВШИН

9.1 Мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт хүрсэн түвшин

Тус төвийн үйл ажиллагааг ТУ-8, ТУ-8.1 маягтуудын дундаж үнэлгээгээр дүгнэхэд 88.69 буюу “Сайн” гэж дүгнэгдэж байна.

Үзүүлэлт	Хувь	Үнэлгээ
ТУ-8 Мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлт	83.46	"Сайн"
ТУ-8.1 Дуудлагын төвийн үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлт	93.92	"Маш сайн"
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ	88.69	"Сайн"

Тус төвийн дотоод үйл ажиллагаа цахимжаагүйгээс ТУ-8 маягтын шаардлагатай судалгаа мэдээлэл ТУНС болон мэдээлэл, судалгаа, статистикийн нэгдсэн системээс гарах боломжгүй байна.

Үзүүлүүд	Хувь	Үнэлгээ
1.Татварын удирдлагын нэгдсэн болон бусад мэдээллийн систем, түүний программ хангамжийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах, өгөгдлийн сангийн нууцлал, аюулгүй байдал, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах.	66.43	"Хангалтгүй"
2.Татварын албаны системийн хэмжээнд ашиглагдах мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн судалгааг хийж, тоног төхөөрөмжөөр хангах, засвар үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулах	95.16	"Маш сайн"
3. Мэдээллийн аюулгүй байдал	100.00	"Маш сайн"
4. ТЕГ-ын дарга, удирдлагын албан үүрэг даалгаврын хэрэгжилт	89.29	"Сайн"
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ	83.46	"Сайн"

Татварын удирдлагын нэгдсэн болон бусад мэдээллийн систем, түүний программ хангамжийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах, өгөгдлийн сангийн нууцлал, аюулгүй байдал, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах:

Энэ үзүүлэлт нь 8 үйл ажиллагааг агуулсан ба тус төвийн “...татварын албаны мэдээллийн технологийн бодлого, чиг хандлагыг тодорхойлох, орчин үеийн технологийн дэвшил, олон улсын сайн туршлагын талаар судалгаа хийж боломжит шийдлийг тодорхойлох, нэвтрүүлэх” чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл **66.43 хувь** байгаа нь ТУНС болон бусад системийн уялдаагүй байдал, мэдээллийн үнэн зөв байдлын баталгаагүй байдал, программын хөгжүүлэлтийн удаашралтай байдалд дүн шинжилгээ хийж, үйл ажиллагааг идэвхжүүлэх, сайжруулахад анхаарах шаардлагатай. МАБ-ын ISO27001 стандартын нэвтрүүлэх ажлын хүрээнд 2022 онд батлагдсан журмуудын үл тохирлыг тодорхойлж, шинэчлэх ажлыг тайлант онд багтаан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

9.2 Дуудлагын төвийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт хүрсэн түвшин

Дуудлагын төвийн үйл ажиллагааг тус төвийн хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд батлагдсан ТУ-8.1 маягтын 4 үзүүлэлтээр 93.92 буюу “Маш сайн” гэж дүгнэгдлээ. Маягтын үзүүлэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг ТУНС болон мэдээлэл, судалгаа, статистикийн нэгдсэн систем авсан болно.

Үзүүлэлтүүд	Хувь	Үнэлгээ
1. Утсаар татварын өр дуудсан байдал	96.62	"Маш сайн"

2. Утсаар зөвлөгөө өгсөн байдал	82.62	“Сайн”
3. Цахимаар зөвлөгөө өгсөн байдал	100.00	“Маш сайн”
4. Гомдол барагдуулсан байдал	90.39	“Маш сайн”
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ		93.92

Тайлант хугацаанд утсаар татварын өр дуудах хэсэгт 6 албан хаагч ажилласан ба нэг өдөрт багадаа 80 дуудлага хийх зарчмыг баримтлан ажилласан байна. Тайлант оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд 70’720 дуудлага хийхээс 63’539 дуудлага хийсэн байна. Тайлант хугацаанд татварын албаны хэмжээнд 38 шугамаар 253’597 хандалт ирснээс 209’521 дуудлагад зөвлөгөө өгсөн бол 14’474 дуудлагыг алдсан байна. Түүнчлэн 29’602 хандалт автомат хариулагчаас мэдээлэл сонссон байна. Тайлант хугацаанд асуулт хариултын санг 21 асуултын хариултаар баяжуулсан байна.

Дуудлагын төв нь татварын албаны хэмжээнд фейсбүүк хаяг, фейсбүүк мессенжер, и-мэйл хаягаар татвар төлөгчдөөс ирсэн нийт 1’723 асуултад хариулт өгч ажилласан байна.

Дуудлагын төв нь татвар төлөгчөөс ирүүлсэн гомдлыг бүртгэн холбогдох татварын хэлтэст шилжүүлэн шийдвэрлүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд татвар төлөгчдөөс 7 төрлийн сувгаар, үүнд:

- 1800-1288 тоот тусгай дугаар
- Цахимаар tcc@mta.gov.mn/
- ЗГ-ын 11-11
- И-баримт аппликейшн
- Биечлэн
- Сошиал хаяг /албаны цахим хуудас болон албан ёсны фейсбүүк хаяг, мессенжер/
- Албан бичиг-р татварын албаны хэмжээнд 16’586 гомдол ирснээс хугацаанд нь 14’854, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 138 гомдол байгаа бол хугацаа хэтэрсэн шийдвэрлээгүй 1’594 гомдол байна.

Дүгнэлт:

1. Таблю системээс гарч буй ижил төрлийн судалгаа мэдээллүүд зөрүүтэй байна.
2. ТУНС, цахим тайлангийн систем, и-баримтын системд хөгжүүлэгдэж буй хөгжүүлэлтийн улдааг хангахад анхаарч ажиллаагүй байна.
3. ТЕГ-ЗББН-с ирж буй бодлогын даалгаварт шинжилгээ хийж, систем, модуль хоорондын уялдааг хангах, алдааг багасгах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.
4. ТУНС-ийн Дуудлагын төв, Татварын үйлчилгээний төвийн хяналт, Өр дуудах төв модулиуд, мэдээлэл, судалгаа, статистикийн нэгдсэн системээс гарч буй мэдээллийг уялдаа, үнэн зөв байдлыг хангаж ажиллаагүй байна.
5. Татвар төлөгчөөс ирүүлсэн гомдлын барагдуулалтыг шийдвэрлүүлэхэд гомдол барагдуулалтын чанарт хяналт тавьж ажилласан байдал хангалтгүй байна.

АРАВ. ЗӨВЛӨМЖ

Татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны түвшин

1. НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдэх босго хангасан татвар төлөгчдийг 4 дугаар улиралд багтаан бүрэн бүртгэх, хасах түүнд хяналт тавих; /Харьяа нэгж/
2. Дүүрэг, аймгийн төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, нутаг дэвсгэрт байрлах үл хөдлөх хөрөнгийн судалгаа, АТБӨЯХ-ийн, бууны, бусад хөрөнгийн судалгааг хороо, баг тус бүрээр гарган, бүртгэлгүй хөрөнгийг илрүүлж бүртгэлжүүлэх байдлаар хөрөнгийн татвар төлөгчийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах, мэдээллийг цэгцэлж, мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг хангах; /Харьяа нэгж/
3. Дүүрэг, аймгийн хэмжээнд өндөр орлоготой иргэдийг тодорхойлох, илрүүлэх, татварт хамруулах талаар дүүрэг, орон нутгийг төрийн захиргааны байгууллагатай хамтарч ажиллах, тодорхойлогдсон иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах; /Харьяа нэгж/
4. Сургалтад хамрагдсан татвар төлөгчийг сургалтын нэр төрлөөр бүртгэлжүүлж, сургалтын үр дүнг тодорхойлж хэвших; /Харьяа нэгж/

Татварын тайлан хүлээн авалтын байдал:

1. Тайлан ирүүлэхгүй байгаа шалтгаан нөхцөлийг татвар төлөгч нэг бүрээр тогтоон, хариу арга хэмжээний санал боловсруулан ТЕГ-ын ТТҮГ-т хүргүүлэх, ТТҮГ нь тодорхой чиглэл гарган албадад хүргүүлэх, хэрэгжилтийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх; /Харьяа нэгж/

2. Төлбөр хураамжийн төрлөөр бүртгэлтэй ГТ-ийн төрлийн бүртгэл, тайлагналыг 2023 оны 12 сард багтаан тулгалт хийж төрлөөс хасах татвар төлөгчдийг журмын дагуу Бүртгэлийн хэлтэстэй зөвшилцөн хасалт хийж баазыг цэгцлэх; /Харьяа нэгж/

3. Х тайлан ирүүлж байгаа ААН-үүдийн тайлагнал ба бусад мэдээллийн уялдааг судлах, хөндлөнгийн мэдээллийг тулгах зэргээр шалтгаан нөхцлийг тогтоох, холбогдох журмын дагуу татан буулгах, бүртгэлээс хасах ажиллагааг хэрэгжүүлэх; /Харьяа нэгж/

Татварын тайлан боловсруулалт, зөрчилтэй тайлан засварлуулсан байдал:

1. Тайлан боловсруулалтын шалгуур хангаагүй тайлан буцаагдсан талаарх мэдээллийг татвар төлөгчид мэдээллийн 2-оос доошгүй сувгаар хүргэх. /харилцах утас, цахим шуудан гэх мэт/

2. Татварын тайлан боловсруулалт, зөрчилтэй тайланг залруулсан байдал ТУ-1.4 2023 оны хагас жилийн байдлаар үнэлгээ хийхэд албадын дунджаас доогуур үзүүлэлттэй Архангай, Баян-Өлгий, Төв, Дархануул, Сүхбаатар, Увс, Өвөрхангай, Дорнод, Орхон, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Хөвсгөл, Ховд, Баянхонгор аймаг, Баянгол, Налайх дүүргийн татварын нэгж онцгой анхаарах

3. Хуваарилагдсан тайлангаас залруулаагүй хүлээн авсан болон залруулаагүй хүлээгдэж буй тайлангийн шалтгаан нөхцөлийг тодруулах нэгдсэн зөрчилтэй тайлангийн судалгаа мэдээлэлтэй болох, 2-с дээш удаа буцаагаад залруулахгүй байгаа тайланг холбогдох нэгжид шилжүүлж ажиллах /260 журмын заалтыг хэрэгжүүлэх/

4. Хүлээн авсан тайлангийн/ААНОАТ, ХХОАТ, НӨАТ, Цалин хөлс/ үзүүлэлт, чанар, борлуулалт, ногдол гэх мэт шаардлагатай үзүүлэлтээр харьцуулсан судалгаа гаргаж, холбогдох санал боловсруулан НТГ, ТЕГ-т хүргүүлж хэвших /, дотоод үйл ажиллагаандаа ашиглах

Татварын орлогын гүйцэтгэл, хураалтын үйл ажиллагааны түвшин Тайлант оны татварын өрийн барагдуулалт

1. Төсвийн тухай хуулийн өр, ногдлын барагдуулалтын шалгуур хувь буурсан боловч зорилтот түвшинд хүрч ажиллаж чадахгүй байгаад дүгнэлт хийн 2023 оны стандарт үзүүлэлтийг хангаж ажиллах. /Харьяа нэгж, НТГ, ТХУАЗГ/

2. Өр хуримтлагдахаас урьдчлан сэргийлэх, ХТМТ-I, II түвшний өрийн барагдалтыг төсвийн тухай хуульд заасан зорилтот түвшингөөс 5 хувиар давуулан биелүүлэх; /Харьяа нэгж/

3. Татварын өртэй татвар төлөгчдөд хуульд заасан шат дараалсан арга хэмжээг авах, гүйцэтгэлийн бие даасан эрх мэдлийн хэрэгжүүлж ажиллах, ХТМТ-III, IV түвшинд хамаарах татвар төлөгчтэй ажиллах ажиллагааг эрчимжүүлэх, өр барагдуулахад хүндрэл үүсч буй шалтгааныг ангилан судалгаа хийж өр барагдуулах ажиллагаа хийсэн нотлох баримт материалыг бүрдүүлэн арга зүйн туслалцаа авах; /Харьяа нэгж/

4. ТУНС болон tableau программын өр, ногдлын мэдээ, тооцоолол, өр, ногдлын үнэн зөв байдалд байнга тулгалт хийж, зөрүү үүссэн нөхцөлд залруулах ажлыг цаг тухай бүр хийх /ТХУАЗГ, МТТ, НТГ Харьяа нэгж/

Татвар хураалтын үйл ажиллагаанд шат дараалсан арга хэмжээ авч ажилласан байдал

1. Хуульд заасан дараалал, хугацаанд татварын өрөнд шат дараалсан арга хэмжээг авч, цаг тухайд нь ТУНС-д бүртгэх; /Харьяа нэгж/

2. ТЕГ-ын дэд даргын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 02/265 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” чиглэлийн дагуу ХТМТ-III, IV түвшинд хамаарах татварын өртэй татвар төлөгчдөд хуульд заасан шат дараалсан арга хэмжээг авах, гүйцэтгэлийн бие даасан эрх мэдлийн хэрэгжүүлж ажиллах; /Харьяа нэгж/

Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны түвшин

1. Нийт албаны хэмжээнд 20 нэгжид хамаарах 103 маргаантай актад холбогдох тайлбар, нотлох баримтыг зохих ёсоор бэлтгэн шийдвэрийг хамгаалах /Харьяа нэгж/

2. Оны сүүлийн хагас жилд татварын хяналт шалгалтын ажлыг томилолтын хугацаанд дуусгахад онцгой анхаарч өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж ажиллах /Харьяа нэгж/

Хөндлөнгийн мэдээлэл цуглуулалт, бүртгэл, ашиглалтын байдал

1. ТЕГ-ын даргын 2020 оны А/113 тоот тушаалаар батлагдсан “Татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулах, санг бүрдүүлэх, ашиглах, сангийн нууцыг хамгаалах журам”-г үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх /Багахангай дүүргийн татварын хэлтэс

2. Хөндлөнгийн мэдээлэл цуглуулах ажлыг нэгж бүрт хувь тэнцүүлэн хуваарилах, ТХШАЭН-ээс бусад нэгжид ажиллаж буй байцаагч нарыг үүрэгжүүлэх, арга зүйгээр хангах /Харьяа нэгж, ЭУГ/

Төрийн захиргаа, хууль эрхзүй, санхүүгийн үйл ажиллагааны түвшин Захиргаа, хүний нөөц, албан хаагчдын сургалтын талаар:

1. Хүний нөөцийн хөдөлгөөн, мэдээллийн өөрчлөлтийг ТУНС-д зөрүүтэй бүртгэсэн бүртгэлийг засаж татварын албаны хэмжээнд хүний нөөцийн мэдээлэл гарах нөхцөлийг бүрдүүлэх; /Харьяа нэгж/

2. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын хэрэгцээг бүх албан хаагчдаас авах, дүгнэлт гарган, саналыг ТЗУГ-т хүргүүлэх, албан тушаал, сэлгэх, шилжих, шинээр албан хаагч томилогдсон үед дагалдуулан сургах ажиллагааг хэвшүүлэх; /Харьяа нэгж/

3. Шинэчлэн батлагдсан “Монголын Татварын албаны ажилтан, албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөр”, “Татварын албаны ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд тухайн жилд хэрэгжүүлсэн ажлыг тоо мэдээ, хүрсэн үр дүнтэй тайлагнаж хэвших, хяналт тавих; /ТЗУГ, Харьяа нэгж/

Хууль, эрх зүйн үйл ажиллагааны талаар:

1. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчил гаргасан хувь хүн, хуулийн этгээдэд хариуцлагын арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, ажил хариуцсан нэгж хяналт тавих/Харьяа нэгжийн ЗХТ/

2. Татварын өртэй татвар төлөгчдийн хөрөнгө байдлыг тогтоох, хөрөнгө, авлагыг битүүмжлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, /Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий, НТГ, ХУД, БГД, НД /

3. Татварын өртэй татвар төлөгчдийн хөрөнгө байдлыг тогтоох, хөрөнгө, авлагыг битүүмжлэх талаар хэрэгжүүлсэн ажиллагааг ТУНС-д бүрэн бүртгэх /Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэг, Өвөрхангай аймаг/

4. Баян-Өлгий, Өвөрхангай, Дорноговь аймгийн татварын хэлтсийн хуулийн мэргэжилтэн нь хэлтсийн даргын тушаал шийдвэрийн төслийг хуулийн зүйл, заалттай уялдуулан хянах

Санхүүгийн талаар:

1. 2023 оны байдлаар авлага, өглөгийн үлдэгдэлтэй татварын албад цаашид төсвийг зохистой удирдаж, авлага, өглөгийг нэмэгдүүлэхгүй ажиллах; /Дорнод, Төв, Хөвсгөл, ТТТГ, НТГ, Баянзүрх, Сонгинохайрхан /

2. Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг хугацаанд нь төрийн аудитын байгууллагад хүргүүлэх; /Харьяа нэгж/

3. Төсвийн шууд захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлж ахин төлбөрийн акт зөрчил гаргахгүй байх / Баян-Өлгий, Говьалтай, Багахангай/

Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийн түвшин

1. Төлбөрийн баримт олгоогүй талаар ирсэн гомдлын хамаарах татвар төлөгчийг тодорхойлж, гомдлыг 100 хувь шийдвэрлэж, дахин гомдол гаргуулахгүй байхаар зөвлөгөө, мэдээлэл өгөх. /Харьяа нэгж/

2. Хууль хэрэгжүүлээгүй татвар төлөгчид хариуцлага хүлээлгэх, хүлээлгэсэн хариуцлагыг ТУНС-д бүртгэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хангаж ажиллах. /Харьяа нэгж/

Мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт хүрсэн түвшин

1. Програм хангамжийн бодлогын даалгавар боловсруулах үйл ажиллагаанд системийн шинжилгээ хийх, систем болон модул хоорондын уялдааг хангуулах /МТТ/

2. Хөгжүүлэлт, сайжруулалт хийгдсэн программ хангамжийг турших, хүлээж авах, татварын албанд нэвтрүүлэх ажлыг холбогдох ЗББН-тэй хамтран хэрэгжүүлэх /МТТ-ЗББН/

3. Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн системийн программ хангамжуудад үзлэг, шалгалт хийх /МТТ/

4. Судалгаа, мэдээллийг гаргах программ бичилтийн дүрэмтэй болох /МТТ/

5. Мэдээлэл, судалгаа, статистикийн нэгдсэн системийн мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих, уялдааг хангах /МТТ/

Эрдэс баялаг, татварын хэлтсийн үйл ажиллагааны түвшин

Харьяа татварын албадад хүргүүлсэн эрдэс баялгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, хуулийн этгээдийн судалгааны үр дүн гарсан зөрчил дутагдлыг арилгасан эсэхэд хяналт тавьж, үр дүнг тооцож хэвших;

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР